

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРААС
2023 ОНЫ 06 ДУГААР САРД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЙЛАН

НЭГ: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТЭС

Дотоод ажил:

Аймгийн Засаг даргын Захирамж А 86, Захирамж Б 2, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын Тушаал А 7, Тушаал Б 4 батлагдсан байна. Үүнээс аймгийн Засаг даргын 86 А Захирамжийг албан ёсны цахим хуудсанд байршуулсан.

Аймгийн Засаг даргын Тамгын газарт 319 албан бичиг ирснээс 50 нь хугацаатай албан бичиг ирж хугацаанд шийдвэрлэсэн. Байгууллагаас 111 албан бичиг бусад байгууллага, иргэнд хүргүүлсэн байна.

Өргөдөл, гомдол, шагнал:

6-р сард иргэдээс аймгийн Засаг дарга, Тамгын газарт хандаж нийт 80 өргөдөл, гомдол ирүүлсний 34 нь Засгийн газрын 11-11 төвөөс ирүүлсэн 46 нь бичгээр болон иргэдийн санал хүсэлт хүлээн авах 7052-11-11 утсаар, <http://dornogovi.gov.mn/> сайт хаягаар ирсэн байна.

Мэдээллийн технологийн чиглэлээр:

Аймгийн ЗДТГ-аас зохион байгуулж буй цаг үеийн мэдээлэлтэй холбоотой 80 мэдээг албан ёсны цахим хуудас болон сайтад байршуулан иргэдэд мэдээлэл хүргэсэн.

Төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааны нэгдсэн систем буюу ERP системийг ашиглах заавар зөвлөмжийг 10 байгууллагын 22 албан хаагчид өгч ажилласан

ХОЁР: ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТЭС:

Төрийн албанд ажиллах мэдээлэл технологийн чиглэлээр нарийн мэргэшсэн, өндөр ур чадвар бүхий ажилтны албан тушаалын цалингийн итгэлцлүүрийг баталсан.

Хүний эрхийн төлөв байдлын тайланг Засгийн газрын Хүний эрхийн хороонд тайлагнах ажлыг зохион байгуулж амжилттай тайлагнасан.

Засгийн газрын 11-11 төвд Замын-Үүд сум дахь боомттой холбоотой ирсэн гомдол, мэдээлэлтэй холбогдуулан боомтын хурал зохион байгуулсан.

Сумдын Засаг дарга нарын цахим хуралд авилгийн эсрэг үйл ажиллагаа болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх цахим нөлөөллийг ажиллагааг идэвхжүүлэн ажиллах чиглэл өгсөн.

Аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөний хэлтэст холбогдох заалт арга хэмжээг тайлагнасан.

Хэлтсийн болон албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнасан.

Иргэнээс ирсэн гомдлын дагуу Сайншанд сумын захирагчийн албаны үйл ажиллагаанд хууль, эрх зүйн чиглэлээр хяналт, шалгалт хийж илтгэх хуудсыг боловсруулан Төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлсэн.

Сайншанд сумын Засаг дарга, тамгын даргаас ирүүлсэн захирамж баримт бичгийг хянан үзэж хариу хүргүүлсэн.

Иргэнээс ирүүлсэн гомдлын дагуу Тамхины хяналтын хуулийн хэрэгжилтийг хангах, холбогдох байгууллагуудтай хамтран тамхи зарах тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийх, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч ажиллах чиглэлийг Сайншанд сумын Засаг дарга, Цагдаагийн газарт хүргүүлсэн.

Иргэдээс ирсэн 3 гомдлыг холбогдох байгууллагад шилжүүлэх, 2 гомдлыг хаах ажлыг зохион байгуулсан.

2023.06.23-ны өдөр “Хамтын ажмллагаа ба эерэг өөрчлөлт” төслийн уралдааны үр дүнгийн уулзалыг зохион байгуулж шалгарсан төслүүдийн хэрэгжүүлсэн үйл ажиллагаатай танилцсан. Энэхүү төслийн уралдааны үр дүнд шинээр нэг төрийн бус байгууллага байгуулагдаж идэвхтэй үйл ажиллагаа явуулж эхэлснээс гадна багш, сурагч, эцэг эхийн хамтын ажиллагааг сайжруулах, соёлоор дамжуулан эерэг нөлөөллийг бий болгох, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, орон нутагтаа ажиллаж амьдрах боломжийг сурталчлан таниулж давхардсан тоогоор 20 гаруй мянган хүнд мэдээллийг хүргэн ажилласан байна.

Хууль тогтоомж тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн тайланг хагас жилээр гаргаж өгсөн.

Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн хагас жилийн тайланг гарган өгсөн

Засгийн газрын хэрэг эрхлэх газрын тайланг хугацаанд нь гарган өгсөн.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн хурал хуралдсан.

Гармын мэдлэг дээшлүүлэх олон улсын өдөр тохиож Ханбаянзүрх хайрхны чиглэлийн хатуу хучилттай авто замтай огтлолцсон төмөр замын гармын тохижилтыг хийж “ТҮР ЗОГС БҮҮ ЯАР” уриатай тэмдэлэн өнгөрүүлсэн.

Үндэсний аюулгүй байдлын хагас жилийн тайланг хугацаанд нь гарган Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд хүргүүлэв.

Аймгийн 2024 оны жилийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэгт ажиллаж хууль зүйн салбараас хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг нэгтгэн боловсруулсан.

Дорноговь аймагт оршин суугаа гадаадын иргэдийн судалгааг гаргаж гадаадын иргэн, харьяатын газрын Дорноговь аймаг дах газрын даргад судалгааг хүргүүлсэн.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны эхний хагас жилийн “Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг Авлигатай тэмцэх газрын дарга, тэргүүн комиссарт хүргүүлэв.

Архивын тасгийн 2023 оны 06 дугаар сард хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан хэлтсийн даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажилласан.

- ❖ Сарын ажлын төлөвлөгөөний дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэв.
- ❖ Архивын тасаг нь 58 албан бичиг хүлээн авч, 17 хариутай бичгийг хугацаанд нь шийдвэрлэсэн.

“Архивын галын аюулгүй байдлын дүрэм” “Байгууллагын архивын үйл ажиллагааны журам”, “Төрийн архивын үйл ажиллагааны журам”, “Архивын баримтын нэр төрөл, хадгалах хугацааны үлгэрчилсэн болон салбарын жагсаалт”-ын зэрэг арга зүйн баримт бичгийн төсөлтэй танилцаж, санал боловсруулж Архивын ерөнхий газарт хүргүүлсэн.

Засгийн газрын 2021 оны 226 дугаар тушаалаар батлагдсан “Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх журам”-ын хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж, Архивын тасагт ирүүлсэн төрийн байгууллагуудын хэвлэмэл хуудасны захиалгыг нэгтгэн, Нийтлэг үйлчилгээний газраар 6 байгууллагын 4 төрлийн хэвлэмэл хуудасны эхийг стандартын бэлтгүүлэн хянаж, хэвлэх зөвшөөрөл олгов.

Төрийн архивын сан хөмрөгийн 2023 оны нөхөн бүрдүүлэлтийн ажлын төлөвлөгөөний дагуу Даланжаргалан сумын ИТХ-ын 2014-2017 оны 50 хадгаламжийн нэгжийг цахим хувийн хамт хүлээн авсан. Айраг, Эрдэнэ сумын орон нутгийн нөхөн сонгуулийн 1930 саналын хуудсыг хүлээн авсан.

Сонгуулийн ерөнхий хорооны 2023 оны 05 сарын 063 дугаар тогтоолын дагуу аймгийн ИТХ-ын даргын 2023 оны 101 дүгээр захирамжаар “Сонгуулийн саналын хуудасыг устгах ажлын хэсэг”-ийг байгуулсан. Ажлын хэсэгт тасгийн дарга, сан хөмрөгч нар ажиллаж, 2023 оны 06 сарын 22-ны өдөр МУИХ болон орон нутгийн 2020 оны сонгуулийн 390 боодол, 55718 саналын хуудсыг устгах ажлыг зохион байгуулж, акт үйлдэв.

Архивын тасгийн 2023 оны цахимжуулалтын ажлын төлөвлөгөөний дагуу Айраг сумын ИТХ-ын 2008 – 2014 оны, 21 хадгаламжийн нэгжийн 2550 хуудас баримт, Хатанбулаг сумын ИТХ-ын 1992 – 2011 оны 29 хадгаламжийн нэгжийн 2503 хуудас баримтыг скайнердаж, Photoshop программаар засварлаж, ашиглалтыг хувь үйлдсэн. Edoc программд Айраг сумын ИТХ-ын 2008 – 2014 оны, 21 хадгаламжийн нэгжийн 2550 хуудас баримтын 492 заалт, 2818 хүний нэр, Хатанбулаг сумын ИТХ-ын 1992 –2011 оны 29 хадгаламжийн нэгжийн 2503 хуудас баримтын 1290 заалт, 2496 хүний нэрийг тодорхойлон бичиж, мэдээллийн сан үүсгэсэн.

Тус тасаг нь энэ сард 90 иргэний өргөдөл, хүсэлтийг хүлээн авч архивын үйлчилгээ үзүүлэв. Нийт 61 иргэнд архивын лавлагаа олгосноос малын А дансны лавлагаа-9, цалингийн тодорхойлолт-29, тодорхойлолт-19, магадлал-4, төрөлтийн бүртгэл-7, гэрлэлтийн бүртгэл-1-г тус тус олгожээ.

Архивын сан хөмрөгийн эх баримт болон цахим сангаас нийт 91 иргэнд 321 архивын баримтын хуулбар олгосон бөгөөд цаасан суурьтай эх баримтаас 104 хуулбар, цахим сангаас 217 хуулбар олгож үйлчилсэн. Мэдээлэл лавлагаанд архивын сан хөмрөгөөс 274 хадгаламжийн нэгж ашигласан.

“Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам”-д заасны дагуу өргөдөл гомдлын бүртгэл, архивын лавлагаа олгосон бүртгэл, архивын баримтын хуулбарын бүртгэл, түр олгосон баримтын бүртгэл, ариутгал хийсэн болон сэлбэн заасан баримтын бүртгэл, уншлагын танхимаар үйлчлүүлэгчдийн бүртгэл, мэдээлэл лавлагаанд ашигласан баримтын бүртгэл болон бусад хүснэгт маягтыг архивын үйл ажиллагаанд тогтмол хөтөлж, хяналт тавьж байна.

Архивын ерөнхий газрын онлайн захиалгын системд 6 иргэний лавлагааг шийдвэрлэж, бусад аймгийн архиваас шийдвэрлэсэн 5 лавлагааг холбогдох эздэд нь хүлээлгэн өгсөн.

Татан буугдсан Мэргэжлийн хяналтын газрын 2003-2022 оны байнга, түр, 70 жил хадгалах 1680 архивын баримтыг бүртгэлтэй нь тулгаж, данс бүртгэлийг төрийн архивын дэргэдэх БНШАЗК-ын хуралд оруулахад бэлтгэж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

2023 оны 06 дугаар сарын цахимжуулалтын ажлын мэдээг гаргаж, Архивын ерөнхий газарт хүргүүлсэн.

Мэдээллийн технологи хариуцсан ажилтан лавлагаанд ашиглах 55 нүүр баримт сканердсан. Нөхөн бүрдүүлэлт хийсэн 2 байгууллагын баримтын мастер хувийг хүлээж авч, Өргөн сумын Эрүүл Мэндийн Төвийн 2012–2016 оны даргын тушаалыг Photoshop программын тусламжтайгаар засварлаж ашиглалтын хувь үйлдсэн.

Архивын 2 хадгаламжийн сангийн чийг дулааныг тогтмол хэмжиж, 7 хоногт 3 удаа чийгтэй цэвэрлэгээ хийлгэж байна.

Төрийн архивын сан хөмрөгийг 2023-2027 онд нөхөн бүрдүүлэх үндсэн болон боломжит эх үүсвэрийн жагсаалтын Архивын ерөнхий газрын дэргэдэх Арга зүйн зөвлөлийн 2023 оны 06 сарын 02-ны 02 дугаар хурлаар хэлэлцүүлэн батлуулав.

Аймгийн ЗДТГ-аас Ноён хутагт Данзанравжаагийн мэлмий гийсний 220 жилийн ойд зориулсан “Ноён хутагтын өв: Өнгөрсөн, одоо, ирээдүй” сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг 2023 оны 06 дугаар сарын 09-ний өдөр Улаанбаатар хотноо зохион байгуулсан. Хурлыг зохион байгуулах ажлын хэсэгт ажилласан.

Д.Равжаагийн “Яруу найргийн цоморлиг”-ийг номын эх бэлтгэлийг хянаж, “Жиком” ХХК-иар 3000 хувь хэвлүүлэхээр гэрээ байгуулан хэвлэлт шилжүүлсэн.

Сайншанд сумын ЗДТГ-ын 2020 оны удирдлагын баримтад нягтлан шалгалт, эрдэм шинжилгээний техник боловсруулалт хийж, бүртгэл үйлдэн, тасгийн мэргэжилтнүүдэд дадлага ажил хийлгэсэн. Тасгуудын хөтлөх хэргийн нэрийн жагсаалт боловсруулах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

Төрийн архивын сан хөмрөгт хадгалагдаж буй Монгол шуудан банк, Хадгаламж, Зоос банк, Нотариатын хадгалах хугацаа дууссан баримтыг ялгаж, Устгах баримтын жагсаалтыг үйлдэж, хуралд оруулахад бэлтгэсэн.

Замын-Үүд боомт, зорчигч тээврийн цогцолборын Гаалийн газрын агуулах, гүнзгийрүүлсэн үзлэгийн саравч, эрэлч нохойн байр, инженерийн дэд бүтцэд холбогдсон

нийтийн бие засах газрын барилга угсралтын ажлын зураг төсөл, техникийн баримт бичгийг архивт хүлээн авч, акт үйлдэв.

Аймгийн ИТХ, ЗДТГ, сумдын ЗДТГ-ын монгол бичгээр үйлдэх албан бичгийн хэвлэмэл хуудсыг Архивын ерөнхий газарт хэвлүүлж, албан хэргийг монгол бичгээр үйлдэх бэлтгэл ажлыг хангаж байна.

Архивын тасгийн ажилчдын өрөө, уншлагын танхимд их засвар хийлгэхээр ажлын зураг, төсвийг мэргэжлийн байгууллагаар хийлгэж байна.

ГУРАВ. НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТЭС

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР:

- ЭМБ-ын статистикч эмч нарыг ЭМС-ын 2019 оны А/611 дугаар тушаалын хэрэгжилтийг шалган арга зүйн зөвлөгөө өгөх ажлын байрны дадлага сургалтад ЭМГ-ын даргын 734 тоот албан бичгээр хуваарь гарган дуудан авчирч ажиллаж байна.
- Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан “Төрийн албаны ёс зүйн тухай” хуулийн танилцуулах сургалтад нийт салбараас 59 хүн хамрагдав.
- ЭМС-ын 2023 оны А/188 тушаалын дагуу 10 сартайгаас 8 настай 6465 хүүхэд буюу хамрагдвал зохих хүүхдийн 48.4%-ийг улаанбурхан улаануудын нэмэлт дархлаажуулалтад хамруулаад байна. Хамралт муу байгаа Сайншанд, Замын -Үүд сумдын ӨЭМТ- үүдэд албан тоот хүргүүлэн амралтын өдрүүдэд явуулын дархлаажуулалт хийх, уртасгасан цагаар ажиллах үүрэг чиглэл өгч ажиллаж байна.
- “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд бэлгийн боловсрол олгох” сургагч багш бэлтгэх 2 өдрийн сургалтыг зохион байгуулж 15 сургагч багшийг бэлдсэн.
- Аймгийн ахмадын хороотой хамтран 1,2,3,4,6,7,8-р багийн ахмадад “Цусны даралт ихсэлт- тархины цус харвалтаас урьдчилан сэргийлэх” сэдэвт сургалтыг хийсэн.
- Хөдөлмөр магадлах комиссын шийдвэрээр шинээр хөдөлмөрийн чадвар алдалт тогтоолгож байгаа 8 хүнээс сэтгэл зүйн байдлыг үнэлэх Спилберг-Ханины сорилыг авч дүгнэсэн.
- Эрүүл мэндийн яамны салбарын хяналтын газрын даргын 2023 онд баталсан “Эмнэлгүүдэд төлөвлөгөөт шалгалт хийх тухай” 10-00/17 дугаартай удирдамжийн хүрээнд Ач үйлс дэлгэрэх ортой хувийн эмнэлэг, Идэр-Өлзийт хувийн ортой эмнэлэг, Уламжлалт анагаах ухаан рашаан сувилалын төв, Монсэй дижи, Хаш-Эрдэнэ, Арвин талст шүдний эмнэлгүүд, Зүүнбаян сумын эрүүл мэндийн төв, Оношлохуй лабораторийн үйл ажиллагаанд эрүүл ахуй халдвар хамгааллын хяналт, эмчилгээний чанарын хяналтын чиглэлээр төлөвлөгөөт шалгалт хийж хуулийн дагуу арга хэмжээ авч ажилласан.эмчилгээний чанарын хяналтын чиглэлээр
- Газар хөдлөлтийн үеийн дадлага сургуулилтад Эрүүл мэндийн албаны бүрэлдэхүүнд орж бэлэн байдлыг шалгуулсан.
- Аймгийн Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн тасгаас ирүүлсэн гомдлын дагуу “Тана босго” ХХК-ийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус шалгалт хийж улсын байцаагчийн актаар үйл ажиллагааг түр зогсоосон.
- Химийн бодисын агуулахад барилга байгууламжийн тухай улсын байцаагчийн дүгнэлт гаргасан.
- “Хүүхдийн хоол” үндэсний чуулганд оролцсон.
- Улсын байцаагчийн албан шаардлагыг биелүүлээгүй 3 сумын Эрүүл мэндийн төвд хариуцлага тооцуулах саналын Засаг дарга нарт хүргүүлсэн.

- Сайншанд сумын 13 дугаар цэцэрлэг, Өргөн сумын ЕБС-д албан шаардлага хүргүүлсэн, Тоонто гранд ХХК-д ариун цэврийн байгууламжид засварын ажлын зураг төсөлд урьдчилан сэргийлэх хяналт хийж дүгнэлт гаргасан.
- Цагдаагийн газрын хүсэлтээр “Согтууруулах ундааг хүнсний зориулалаар ашиглаж болох эсэх” талаар шинжээчийн 2 дүгнэлт гаргасан.
- Эрүүл мэндийн яамны Салбарын хяналтын газрын даргын 2023 онд баталсан 10-00/17 дугаартай удирдамжийн дагуу Сайншанд сумын 3 дугаар багт байрлах “Монсэй дижи” шүдний эмнэлэг, Сайншанд сумын 2 дугаар багт байрлах “Оношлохуй” лаборатори, Сайншанд сумын 2 дугаар багт байрлах “Уран дэлгэц” эмэгтэйчүүдийн үүдэн эмнэлгийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт шалгалт хийж зөрчил илрүүлсэн. Илрүүлсэн зөрчлийн мөрөөр 10-21-02/088/03, 10-21-01/090/04, 10-21-01/090/05 дугааруудтай Хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг явуулж аймгийн Прокурорын газарт бүртгүүлсэн.
- УБТЗ-ын Сайншанд дахь худалдааны төвийн Ган зам талхан цехэд хүнсний эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын чиглэлээр төлөвлөгөөт шалгалт хийж гүйцэтгэсэн.
- Замын-Үүд суманд нээгдэх өдөр өнжүүлэхийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт хийж ажилласан.
- Агатова, Талст зам, Мишээлт мана өрхийн эрүүл мэндийн төвүүд, Ач үйлс дэлгэрэх хувийн ортой эмнэлэгт гүйцэтгэлийн шалгалт хийж гүйцэтгэв.
- Боловсрол шинжлэх ухааны яамны цөмийн болон цацрагийн хяналтын улсын байцаагч нарын хамт аймгийн Нэгдсэн эмнэлэгт 10-00/17 “Эмнэлгүүдэд төлөвлөгөөт шалгалт хийх тухай” удирдамжийн хүрээнд төлөвлөгөөт шалгалт хийж гүйцэтгэв.
- “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах тухай” сургалтад хамрагдсан.
- Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн гэрээний заалтад үнэлгээ өгсөн.
- Хүүхдийн баярын урьдчилан сэргийлэх шалгалт хийсэн.
- Дорноговь аймгийн Сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны хэрэгцээт эм эмнэлгийн хэрэгсэл худалдан авах харьцуулалтын тендер зарлан 2023-06-16-д нээлт хийж, 5,6,7,8,15 дугаар багц Монос Дорноговь ХХК шалгарч, 1.9 сая төгрөгний хэмнэлттэй, ЭМГ-ын 2023 оны А/94 дүгээр тушаалаар гэрээ байгуулан ажиллав.
- Сумын эрүүл мэндийн төвүүдийн ерөнхий гэрээгээр нийлүүлэх эм эмнэлгийн хэрэгслийн судалгааг авч Цахим тендер зарлан, үр дүнг 2023 оны 06 сарын 30-ны 13 цаг 30 минутад нээж, гэрээ байгуулах ажлыг зохион байгуулахаар төлөвлөж байна.
- Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх үндэсний хэмжээнд зохион байгуулагдсан “Стратегийн команд штабын сургууль”-д 6 сарын 7-9-ний өдрүүдэд оролцож, аймгийн “Ослын удирдлагын тогтолцоо” -ны бүрэлдэхүүнээр ажиллаж, газар хөдлөлтийн үеийн ширээний дадлага, сургуулилт хийлээ. Мөн Гамшгийн аюулын зарлан мэдээлллийн дуут дохиогоор газар хөдлөлтийн үед аюулгүй талбайд ЭМГ-ын 20 албан хаагч цугларч, Эрүүл мэндийн алба, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн 58 хүний бүрэлдэхүүнтэй бэлэн жагсаж, аранзны үзлэгт орсон.
- Сувилахуйн мэргэшлийн зэргийн шалгалтад орох хүсэлт гаргасан 23 сувилагчийг материалыг хянаж цахимд оруулан хүсэлтийг монголын сувилагчдын нийгэмлэгт хүргүүлсэн
- ЭМЯ, ЭМХТ-өөс ажлын хэсэг орон нутагт ажиллаж, 2023 оны 6 дугаар сарын 12-14-ны өдрүүдэд “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, үйлчлүүлэгчийн аюулгүй байдал” сэдэвт сургалт зохион байгуулж, сургалтад Нэгдсэн эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төв, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын чанар, аюулгүй байдлын алба, багийн дарга болон гишүүд, нийт 68 эмнэлгийн мэргэжилтэн хамруулж, 2 багц

цагийн гэрчилгээ олгосон. Аймгийн Нэгдсэн эмнэлэг, Ачлал, Ач үйлс дэлгэрэх эмнэлгийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, үйлчлүүлэгчийн аюулгүй байдал болон магадлан итгэмжлэлийн явцын дэмжлэгт хяналт үнэлгээ хийж, газар дээр нь арга зүйн дэмжлэг үзүүлэн ажиллав.

- Тусгай зөвшөөрлийн комиссын 6.7 дэх хурлыг хийж, 6 асуудлыг хэлэлцэж шийдвэрлэв, Ханги боомтын эмийн сангийн төсөл дээр шинжээчийн баг ажиллаж, дүгнэлт гаргасан.
- Магадлан итгэмжлэлд орох 5 ЭМБ-ын хүсэлт, 22 шаардлага, 14 материалд хяналт хийж, арга зүйн зөвлөгөө өгч, цахим программаар ЭМХТ-д илгээсэн. ЭМГ-ын даргын батлагдсан удирдамжийн дагуу Хатанбулаг, Хөвсгөл, Зүүнбаян, Талст зам эрүүл мэндийн төвийн магадлан итгэмжлэлийн бэлтгэл ажилтай танилцаж, газар дээр нь арга зүйгээр хангасан
- Эрүүл мэндийн яамны санхүү эдийн засгийн газарт Ковид-19 цар тахлын үед нийлүүлэгдсэн хугацаа дууссан эм эмнэлгийн хэрэгслийн судалгааг гарган Эрүүл мэндийн газрын 2023 оны 766 дугаар албан бичгээр хүргүүлэн ажиллаа.
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөөний хэрэгжилтийг гаргаж, ЭМЯ -нд хүргүүлсэн.
- Гэрээр үзүүлэх сувилахуйн тусламж үйлчилгээ сайжруулах зорилгоор “Гэрийн сувилахуйн тусламжийг сайжруулъя” 1 сарын аян 2023 оны 05 сарын 24 –өөс 06 сарын 24-ний хооронд зохион байгуулж 142 иргэнд гэрийн асаргаа сувилгаа, 378 иргэн, ар гэрийхэнд гарын доорх материал ашиглан хийсэн асаргааны иж бүрдлээ танилцуулан асаргаа сувилгаа зааж зөв зохистой хоол хүнс, ханиад томуунаас урьдчилан сэргийлэх иллэг, эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх сургалт сурталчилгааг зохион байгуулж 4 төрлийн 208 ш гарын авлага, 147.9 мян төгрөгийн асаргаа сувилгааны иж бүрдэл авч, эмийн сангууд 98.3.0 мян төгрөгийн дархлаа дэмжих бүтээгдэхүүн дэмжлэг үзүүлсэн

БОЛОВСРОЛЫН ЧИГЛЭЛЭЭР:

- Суурь, бүрэн дунд боловсролын гэрчилгээ, үнэмлэхийг Боловсролын салбарын мэдээллийн системээс 2019 оноос хойш 5 дахь удаагаа хэвлэн олгож байна. Ингэснээр суурь, бүрэн дунд боловсролын гэрчилгээ, үнэмлэхийн лавлагаа E-MONGOLIA мэдээллийн системээс 2019 оноос хойш 7 ардаг болсон. 2022-2023 оны хичээлийн жилд ЕБС-ийн 21 сургуулийг дүйцсэн хөтөлбөрөөр болон ердийн хөтөлбөрөөр төгсөж буй 9-р ангийн 1266 сурагчийн суурь боловсролын гэрчилгээ, 12-р ангийн 548 сурагчийн бүрэн дунд боловсролын гэрчилгээг боловсролын салбарын мэдээллийн системээс амжилттай хэвлэж төгсөгчдөд гардууллаа.
- Элсэлтийн ерөнхий шалгалт 6 сарын 15-18-ны өдрүүдэд Сайншанд сумын 1-р сургууль, Замын-Үүд сумын 3-р сургууль дээр зохион байгуулагдлаа. Элсэлтийн ерөнхий шалгалтад Замын-Үүд суманд 151, Сайншанд суманд 436 шалгуулагч, нийт 587 хүн шалгалтад орохоор бүртгүүлснээс 10 хичээлийн давхардсан тоогоор 1667 шалгуулагч орохоос 1463 буюу 87.7 хувь нь хамрагдлаа.
- 2022-2023 оны хичээлийн жилийн эцсийн улсын шалгалтуудыг сургууль бүр авч үнэлгээг хийлээ. Мөн 6 сарын 05-08-ны өдрүүдэд монгол хэл, математик, сонгох шалгалт, гадаад хэлний хичээлийн 9, 12-р ангийн улсын шалгалт зохион байгуулагдлаа. Улсын шалгалтад 22 сургуулийн 9, 12-р ангийн 1814 сурагч хамрагдлаа. Улсын шалгалтын явцад БШУГ-ын 11 мэргэжилтэн хөндлөнгийн хяналт тавин ажиллалаа.
- Дорноговь аймгийн Онцгой байдлын газраас “Өсвөрийн аврагч - 2023” аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг ЗДТГ, БШУГ, ГБХЗХГ, Дэлхийн зөн Монгол Олон улсын байгууллага, Улаан загалмайн дунд шатны хороотой хамтран зохион байгууллаа. Тэмцээнд 9 багийн 63 сурагч оролцож, анхан шатны тусламж үзүүлэх, хүний амь, эрүүл мэндийг авран хамгаалах, гал унтраах, химийн хордолтын бүсэд ажиллах зэрэг олон

төрлөөр өөрсдийн авхаалж самбаа, ур чадвараа шалгаж оролцсоноос: - Тэргүүн байрт Сайншанд сумын 4 дүгээр сургууль, - Дэд байрт Айраг сумын ерөнхий боловсролын сургууль, - Гутгаар байрт Сайншанд сумын ерөнхий боловсролын 6 дугаар сургуулийн баг тамирчид тус тус шалгарлаа.

- Орон нутаг болон сургуулийн түвшинд багш нар харилцан суралцах, хамтран хөгжих шинэлэг соёл, арга барилд суралцаж, багшлахуйд болон хүүхдийн хөгжил, сурах арга барил, сурлагын чанарт ахиц гаргах зорилгоор нэгдэн Мэргэжлийн хөгжлийн бүлгийг судлагдахуун ба суралцахуйд суурилсан 2 хэлбэрээр зохион байгуулж ажилласан. Судлагдахуунд суурилсан МХБ-ээр математик, физик, англи хэл, монгол хэл, дизайн технологи, бага анги, дуу хөгжмийн судлагдахууны багш нар ажиллаж, 524 багш, 22135 сурагч, суралцахуйд суурилсан МХБ-ээр ЕБ-н 22 сургуульд 23 МХБ ажиллаж, 483 багш, 8767 сурагч хамрагдан сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад тулгамдаж байгаа асуудлаа илрүүлж, хамтран шийдвэрлэн сайн туршлагаа түгээн дэлгэрүүлж ажиллалаа.
- Эрээн хотын консулын газар, АЗДТГ, БШУГ хамтран зохион байгуулсан "Эрээн хотын 1 өдрийн аялал"-д Сайншанд сумын 5, Замын-Үүд сумын 3 сургуулийн 200 гаруй сурагч, 20 багш хамрагдлаа. Аяллаар Эрээн хотын 3 дугаар сургууль, Үлэг гүрвэлийн музейгээр зочилж, байгаль орчин, танин мэдэхүйн мэдлэгээ хөгжүүлэн, 1 өдрийг сонирхолтой, дурсамжтай өнгөрүүллээ.
- Монголын хүүхдийн спортын VII наадам спортын 23 төрлөөн зохион байгуулагдаж, 5000 гаруй тамирчид оролцсон байна.
- Дорноговь аймгийн Засаг даргын нэрэмжит аймгийн аварга шалгаруулах Цэрэг-спортын "Дөл-2023" цогцолбор зохион байгуулагдлаа. Тус тэмцээн нь хүүхэд, залуучуудад цэрэг, эх оронч үзэл төлөвшүүлэх, бие бялдрын болон ёс суртахуун, сэтгэл зүйн хүмүүжил олгох зорилготойгоор жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг. Тэмцээнд 11 сургуулийн 120 гаруй тамирчид, дасгалжуулагч оролцож тэсвэр хатуужил, авхаалж самбаа, хурд, хүчээ сорин өрсөлдсөнөөс: - Тэргүүн байранд Сайншанд сумын Зүүнбаян багийн ЕБ-ын 4 дүгээр сургууль, - Дэд байранд Сайншанд сумын ЕБ-ын 1 дүгээр сургууль, - Гутгаар байранд Айраг сумын ЕБ-ын сургууль, - Тусгай байранд Замын-үүд сумын ЕБ-ын 1 дүгээр сургууль тус тус шалгарлаа.
- "Эрүүл аж төрөхүй" эрүүл мэндийн 2 дугаар олимпиадыг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, ЭМГ, БШУГ-тай хамтран аймгийн ЕБ-ын 21 сургуулийн 7, 10-р ангийн 1834 сурагчдын дунд амжилттай зохион байгууллаа. 7-р ангийн төрөлд: - 1-р байр-Б.Отгон багштай Сайншанд сумын ЕБ-ын 3-р сургуулийн 7б ангийн хамт олон - 2-р байр-Ч.Батзаяа багштай Сайншанд сумын ЕБ-ын 1-р сургуулийн 7д ангийн хамт олон - 3-р байр-О.Мөнх-Эрдэнэ багштай Хатанбулаг сумын ЕБС-ийн 7б ангийн хамт олон 10-р ангийн төрөлд: - 1-р байр-Д.Байгалмаа багштай Сайншанд сумын ЕБ-ын 3-р сургуулийн 10б ангийн хамт олон - 2-р байр-И.Хонгорзул багштай Сайншанд сумын ЕБ-ын 2-р сургуулийн 10а ангийн хамт олон - 3-р байр-Т.Ууганбаяр багштай Замын-Үүд сумын ЕБ-ын 3-р сургуулийн 10а ангийн хамт олон тус тус шалгарлаа.
- Шинжлэх ухаан, технологи, инновацын салбарын өнөөгийн байдал, үйл ажиллагаа, хөгжлийн бодлого, зорилт, хууль эрх зүйн орчны талаар дэлгэрэнгүй мэдээлэл хүргэх, шинжлэх ухааны байгууллага, судлаачдын орон нутгийн хөгжилд оруулах хувь нэмэр, үүрэг оролцоог дээшлүүлэх, түүнчлэн орон нутагт шинжлэх ухаан, технологи, инновацын үйл ажиллагаа явуулах, зөвлөлийн үйл ажиллагааг тогтворжуулахад учирч буй хүндрэлтэй асуудлыг ярилцах, шийдвэрлэх арга замыг эрэлхийлэхэд чиглэгдсэн "Инновацыг орон нутагт" сэдэвт аймаг нийслэлийн ШУТИйн зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга нарт зориулсан мэргэжил аргазүйн сургалтад ЗДТГ-ын мэргэжилтэн А.Баянжаргал, БШУГ-ын мэргэжилтэн Ц.Шүрэнцэцэг нар хамрагдлаа.

- Говийн V дүрийн ноён хутагт Лувсанданзанравжаагийн мэлмий гийсний 220 жилийн ойг угтуулан “НОЁН ХУТАГТЫН ӨВ: ӨНГӨРСӨН, ОДОО, ИРЭЭДҮЙ” сэдвийн олон улсын эрдэм шинжилгээний VI хурал зохион байгуулагдлаа. Тус эрдэм шинжилгээний хуралд 40 эрдэмтэн, судлаач оролцсоноос 5 нь гадаадын эрдэмтэн судлаачид бөгөөд энэхүү хурлаар Ноён хутагтын намтар, бүтээлд холбогдох судалгаа, гадаад дахь ноён хутагт судлал, өв хүн төрөлхтний соёлын өв, шашин, гүн ухааны судалгаа, урлаг, утга зохиол, соёлын судалгаа, түүхэнд холбогдох аман түүх, хууч яриа, ноён хутагтын түүхэн дурсгалт газрууд гэсэн сэдвээр илтгэл хэлэлцүүлээ.
- БШУ-ны сайдын А/49 дүгээр тушаалын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Боловсролын ерөнхий газар, аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар хамтран ЕБ-ын сургуулийн менежментийг сайжруулах чиглэлээр зөвлөн туслах үйл ажиллагааг Дорноговь аймгийн Сайншанд сумын ЕБ-ын 1-р сургууль, Иххэт сумын ЕБ-ын сургуульд 3 дахь удаагаа зохион байгууллаа.
- “Боловсролын чанарын шинэчлэл” төслийг бага боловсролын эх хэл, математик чадварыг ахиулахад дэмжлэг болох зорилгоор Боловсрол, шинжлэх ухааны яамнаас Дэлхийн банкны санхүүжилтээр 2015-2023 оны хооронд амжилттай хэрэгжүүллээ. Уг төсөл нь Монгол улсын бүх өнцөг булан бүрд хүрч, бага ангийн анги танхим, багш, хүүхэд бүрийн өдөр тутмын үйл ажиллагаанд дэмжлэг болж чадсанаараа онцлогтой бөгөөд үр шим хүртэгчид нь Монгол улсын 21 аймаг, 9 дүүргийн бага боловсролын хөтөлбөртэй төрийн өмчийн бүх ерөнхий боловсролын сургуулийн 1376 удирдах ажилтан, 12100 бага ангийн багш, 382000 сурагч, тэдний эцэг эх, асран хамгаалагчид байна. Төслийн хаалтын үйл ажиллагаанд 200 гаруй төлөөлөгч оролцсоноос Дорноговь аймгаас 5 албан хаагч оролцлоо.
- “Боловсролын чанарын шинэчлэл” төслийн хүрээнд СТЕМ боловсролын хэрэглэгдэхүүнийг бүтээлчээр ашиглах үйл явцыг дэмжих, үндэсний хэмжээний идэвхжүүлэх үйл ажиллагааг Боловсролын ерөнхий газрын даргын 2023 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/98 дугаар тушаалын дагуу, үйл ажиллагааны удирдамж, чиглэлийн хүрээнд 21 аймаг, нийслэлийн 9 дүүргийн нийт 506 сургуулийн багш, сурагчдыг хамруулан 3 үе шаттайгаар зохион байгууллаа. “БҮТЭЭЛЧ БАГАЧУУД, ШИЛДЭГ АРГА ЗҮЙ-2023” уралдааны үндэсний шалгаруултад 20 баг, 10 шилдэг багш оролцсоноос “Шилдэг арга зүйтэй багш” ангилалд Замын-Үүд сумын ЕБ-ын 2 дугаар сургуулийн бага ангийн багш Б. Гүнжиймаа ТУСГАЙ байрт шалгарч ТАБЛЕТ-аар шагнууллаа.
- Дорноговь аймгийн Засаг даргын үйл ажиллагааны “Хөгжлийн төлөө хамтдаа-2” хөтөлбөр, “Хүүхдэд ээлтэй орон нутаг” аймгийн зорилтот хөтөлбөр, “Чадварлаг багш” арга хэмжээний хүрээнд багшийг чадавхжуулах, тэргүүн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, сурагчдын сурлагын чанар, ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор 2022-2023 оны хичээлийн жилийн Элсэлтийн ерөнхий шалгалтад Нийгэм судлалын чиглэлээр 800 оноо авч, сурлагын өндөр амжилт үзүүлсэн Сайншанд сумын ЕБ-ын 1-р сургуулийн 12а ангийн сурагч Б.Ганчимэг, бэлтгэсэн багш Э.Алтантуяа нарыг аймгийн Засаг дарга О.Батжаргал хүлээн авч, урамшууллаа.
- БНХАУ-ын ӨМӨЗО-ны Бугат хот, ОХУ-ын Читай хот, Монгол улсын Дорноговь аймаг, Орхон аймгийн удирдлагууд, Боловсролын салбарын удирдлагуудын хамтарсан гурван улсын түүхэн уламжлалт хамтын ажиллагааг бүс нутгийн түвшинд бэхжүүлэх, боловсролын салбарын хамтын ажиллагааг хөгжүүлэх, харилцан нягт хамтран ажиллах, соёлын өвийг сурталчлан таниулах, аймаг хотын иргэд, хүүхэд, залуусын найрамдалт харилцааг батжуулах зорилтын хүрээнд 2023.06.14-ны өдөр цахим хэлэлцүүлгийг зохион байгуулж, цаашдын хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурлаа.

ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Хүүхдийн хөгжил оролцоо, эрхийг хамгаалах чиглэлээр:

- Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр хүүхдийн баярын нээлтийн үйл ажиллагааг “нэгдүгээрт хүүхэд” уриан дор авьяаслаг 300 хүүхдийн тоглолтыг зохион байгууллаа. Мөн зорилтот бүлгийн болон урлаг спортын амжилт гаргасан 230 хүүхдийн гарын бэлгийн аймгийн Засаг даргын гарын бэлэг, гэр бүл, хүүхэд, залуучуудын чөлөөт цагаа өнгөрүүлэх 6 талбайд 49 төрлийн тэмцээн уралдааныг зохион байгуулж 216 хүүхдийг гарын бэлгээр тус тус шагнаж урамшуулсан. Түүнчлэн Залуучуудын хөгжлийн төвийн дэргэдэх Рубик шооны дугуйлан, Уран бичлэгийн дугуйлан үзүүлэн хичээл зохион байгуулж 100 хүүхэд хамрагдлаа.
- “Найз байя” аяны хүрээнд Сайншанд сумын ЕБ-ын 1 дүгээр сургуулийн 6г ангийн 35 хүүхдэд үе тэнгийн дээрэлхэлт, ялгаварлан гадуурхалтын тухай болон хуулиар хамгаалагдсан эрхээ зөрчигдөхөд хаана хэнд хандах, өөрийгөө болон найзыгаа эрсдэлт хүчин зүйлсээс хэрхэн яаж хамгаалах талаар мэдлэг олгосон сургалт зохион байгууллаа. Сургалтаар хүүхдүүд бие биендээ хүндэтгэлтэй хандах, дээрэлхэлт ялгаварлан гадуурхалтын ялгаа, хор уршиг, сөрөг үр дагавар, үүнээс үүдэлтэй хэн нэгний эрх зөрчигдөж ямар эрсдэлт өртдөг талаар ойлголттой болсон.
- “Хүүхдийн тэвчишгүй хөдөлмөрийг устгах олон улсын өдөр”-ыг тохиолдуулан 7 төрлийн зурагт хуудас, постерыг байгууллагын цахим хаягт байршуулж иргэд олон нийтэд мэдээллийг хүргэсэн. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас зохион байгуулсан “Цахим орчны хүүхэд хамгаалал-2023” цахим сургалтад тус байгууллагын Хүүхэд хамгаалал хариуцсан мэргэжилтнийг хамруулсан.
- “Хүүхэд хөгжлийн хөтөлбөрийн зүүн бүсийн хүүхдийн чуулган улаанбаатар хотын тэрэлжид байрлах баянгол хүүхдийн зусланд “Нэгдүгээрт хүүхэд” уриан дор Дорноговь, Дорнод, Хэнтий, Сүхбаатар аймгийн нийт 177 хүүхдийг хамруулан 2023 оны 06 сарын 25-29-ний өдрүүдэд зохион байгуулагдсан. Чуулганд Дорноговь аймгийн 40 хүүхэд, 5 албан хаагч оролцсон. Хүүхдүүд Өвөл, Хавар, Зун, Намар гэсэн дөрвөн бүлэгт хуваагдан байрлаж, “Сайн байна уу зуслан минь”, “Хамтдаа бүтээцгээе”, “Монголын Хүүхдийн зөвлөлийн чуулган”, “Цахим орчны зохистой хэрэглээ”, “Монгол бахархал”, “Баяртай зуслан минь” зэрэг зуслангийн хөгжлийн хөтөлбөрт хамрагдаж, багаар ажиллах, өөрийгөө танин мэдэх, бусдыг хүндэтгэх, байгаль, эх орноо хайрлахад суралцахаас гадна шинэ найз нөхөдтэй болж, цагийг бүтээлч, хөгжилтэй өнгөрүүлсэн. Байгууллагын даргын тушаалаар 7,5 сая төгрөгийг зарцуулсан.

Хүүхэд хамгааллын чиглэлээр:

- Хүүхдийн тусламжийн 108 утсанд Сайншанд, Замын-Үүд, Айраг сумдын 17 дуудлага мэдээллийг хүлээн авч холбогдох хамтарсан багт шилжүүлж, хяналт тавьж ажилласан. Өмнөх оны мөн үеэс 4 дуудлага мэдээлэл буюу 30,8 хувиар өссөн. Дуудлага мэдээллийн төрлөөр нь авч үзвэл бие махбодын хүчирхийлэл 1, хараа хяналтгүй 1, сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн 4, үл хайхрах хүчирхийлэлд өртсөн 1, хууль эрх зүйн зөвлөгөө тусламж хүссэн 1, хүүхдийн тэвчишгүй хөдөлмөр эрхлэлттэй холбоотой 2, бие махбодын хүчирхийлэлд өртсөн 1, бэлгийн хүчирхийлэл буюу биеийн эмзэг хэсгүүдэд зөвшөөрөлгүй хүрсэн 5 дуудлага мэдээллийг ирүүлсэн байна. Дуудлага мэдээллийн шийдвэрлэлт 77 хувьтай байна.
- Хүүхдийн эрхийн тухай хуулийн дагуу 18 насанд хүрээгүй 4 хүний оролцсон гэмт хэргийн хохирогч, зөрчил гаргагч хэрэгт тус байгууллагаас Цагдаагийн газарт хууль ёсны төлөөлөгчийг томилон хүүхдийн эрхийг хангаж ажиллалаа.

- Сайншанд, Замын-Үүд сумдын түр хамгаалах байраар нийт 2 хүүхдийг хүлээн авч 30-90 дэх хоногтоо хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээг үзүүлж байна. Эдгээрээс бэлгийн хүчирхийллийн хохирогч Н-ийн хууль ёсны төлөөлөгчийг цагдаа, прокурорын холбогдох албан хаагчидтай уулзуулж хэргийн бүртгэлийн явц дахь хүүхэд хамгааллыг хангаж ажилласан.
- Аймгийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт хорихоос өөр төрлийн ял шийтгэлтэй байгаа 9 хүүхдэд сургалтын төлөвлөгөөний дагуу зан үйл засах өөртөө итгэх итгэл, харилцаа хандлага, ирээдүйн зорилго тодорхойлох ярилцлага өрнүүлж санаа бодлын сонсож, зөвлөх үйлчилгээ үзүүлэн ажиллалаа.
- 2017 онд Б гэх эмэгтэй насанд хүрээгүй У гэх 3 настай охиноо дагуулаад БНХАУ-ын ӨМӨЗО-ны Зүүн сөнэд тосгонд очиж амьдарсан энэ хугацаанд хятад иргэн Цэнгэлтэй хамтран амьдарч гэр бүл болсон. Насанд хүрээгүй 3 настай охиныг орхиж Монгол улсад орж ирсэн кейс 2022 онд Хүүхдийн тусламжийн 108 утсанд ирснийг шалгаж уг кейс дээр Хүн худалдаалах Хүйсийн тэгш эрхийн төв ТББ, Цагдаагийн Ерөнхий газар, Замын-Үүд сумын Засаг даргын тамгын газар, Эрээн хотын Консул Т.Мөнхгэрэл нартай хамтран 2023.06.05-6-ны өдрүүдэд ажилсан. БНХАУ-ын Эрээн хотын Зүүн сөнэд тосгонд 5 жил болсон байсан бөгөөд өдгөө 9 настай У охиныг Монгол улсад буюу Замын-Үүд суманд авчирч эмээ, өвөө ар гэрийнхэнтэй нь уулзуулсан. Улаанбаатар хот руу ээж Б, У охин, хятад иргэний хүү О (5 настай) хүүгийн хамт хүргэж өгсөн. Гадаадад ажилласан зардал мөнгө санхүүгийн асуудлыг Замын-Үүд сумын Засаг даргын Тамгын газар шийдвэрлэсэн.

Залуучуудын хөгжлийг дэмжих чиглэлээр:

- Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Зэвсэгт хүчний жанжин штабын ерөнхий газрын хамтран ажиллах төлөвлөгөөний хүрээнд Зүүнбаян дахь Зэвсэгт хүчний 336-р ангийн бие бүрэлдэхүүнд жендэрийн тэгш байдал, харилцаанд нөлөөлдөг хүчин зүйлс сургалт, хосын карт арга хэмжээг тус тус зохион байгуулж 350 хугацаат цэргийн албан хаагч, офицеруудыг хамруулж тус байгууллагаас 1,4 сая төгрөгийг зарцуулсан.
- “Сонгогчдын боловсрол төв” төрийн бус байгууллага, Сонгуулийн ерөнхий хороо болон аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газартай хамтран “Оролцоно, төлөөлнө” өдөрлөгийг зохион байгуулсан. Тус өдөрлөгт залуу үеийн төлөөллүүд оролцож, Бид хэнд саналаа өгдөг вэ?, Сонгуулийн автоматчилагдсан систем, Мэргэжилд хүйс хамаатай юу? зэрэг сургалтыг зохион байгуулж 120 хүүхдийг 8 өртөө болгон тоглоомын аргаар сонгуулийн үйл ажиллагаа болон саналын хуудас уншуулах, жендэрийн хэвшмэл ойлголтын талаар мэдлэг олгосон.
- Оюутан залуусын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилтын хүрээнд цагийн ажлын байранд орон нутгийн 4 оюутныг өдрийн ажлын байр 2 залууг байнгын ажлын байранд холбон зуучилсан. Залуучуудын хөгжлийн төвийн дэргэдэх гитар, мэтгэлцээний дугуйлангийн шинэ элсэлт эхэлж 10 хүүхэд, 3 насанд хүрэгчийг хамруулсан.

Гэр бүл, иргэд олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах чиглэлээр:

- Аймгийн прокурорын газартай хамтран эрсдэлд нөхцөлд амьдарч байгаа болон хохирогч хүүхдүүдийн сэтгэл зүйд гарч байгаа хохирлыг арилгах сэтгэл заслын үйлчилгээг үзүүлэх сургалтыг “Монгол өрх” сэтгэл зүйн хүрээлэнтэй хамтран зохион байгуулж “Монгол өрх” сэтгэл зүйн хүрээлэнгээс аймгийн Засаг даргын Тамгын газар, Цагдаагийн газар, Прокурорын газар, Боловсрол шинжлэх ухааны газар, ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч зэрэг нийт 30 гаруй албан хаагчдад мэдлэг мэдээлэл олгосон. Уг арга хэмжээний зардалд тус байгууллагын урьдчилан сэргийлэх арга

хэмжээний бусдаар гүйцэтгүүлэх төлбөр хураамжийн зардлаас 500,000 төгрөгийг зарцуулсан. Эрсдэлд нөхцөлд амьдарч байгаа болон хохирогч хүүхдүүдийн сэтгэл зүйд гарч байгаа хохирлыг арилгах сэтгэл заслын үйлчилгээг үзүүлэх төрийн байгууллагын үүрэг оролцоог сайжруулсан.

- Сайншанд сумын эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа 150 өрхөд 2023 оны 05 дугаар сард “Миний гэр-Миний аюулгүй орчин” нөхцөл байдлын үнэлгээг багийн ажлын албатай хамтран зохион байгуулсан ба уг үнэлгээгээр цахилгааны утас ил холболттой болон аюулгүй байдлын эрсдэлтэй 33 өрхийг илрүүлсэн. Өрхүүдийн мэдээллийг Цахилгаан түгээх сүлжээ салбарт хүргүүлэн цахилгааны аюулгүй байдлыг ханган, хамтран ажиллаж хариу мэдэгдэх талаар албан бичгийг хүргэсэн.
- Сайншанд сумын Зүүнбаян 5-р багт “Миний гэр-Миний аюулгүй орчин” нөхцөл байдлын үнэлгээнд эрсдэлт нөхцөлд амьдарч буй хүүхэдтэй өрх, бүтэн, хагас өнчин хүүхэдтэй 18 өрх хамрагдаж үнэлгээгээр хүнс тэжээлийн дутагдалтай байгаа 5 өрхөд тус бүрд 67150 төгрөгийн бүтээгдэхүүн нийт 335,750 төгрөгийн хүнсний дэмжлэг үзүүлсэн.

Төрийн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, хөтлөн явуулах чиглэлээр:

- Төрийн албан хаагчдын Нийгмийн баталгааны хөтөлбөрийн хүрээнд төрийн үйлчилгээний 11 албан хаагчдад ур чадварын нэмэгдэл, 2 албан хаагчид зэрэг дэвийн нэмэгдэл, 19 албан хаагчдад хоолны мөнгийг нэмэгдүүллээ. Түүнчлэн төрийн албан хаагчдад хагас жилийн тайлан бичихтэй холбоотой 13 албан хаагчдад тайлан бичих арга зүйн сургалтыг зохион байгуулсан.


СОЁЛ УРЛАГЫН ЧИГЛЭЛЭЭР:

ЗОРИЛТОТ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ:

Аймгийн Засаг даргын “Хөгжлийн төлөө хамтдаа-II” үйл ажиллагааны хөтөлбөр, “Нээлттэй Дорноговь” зорилтот жил, Говийн ноён хутагт Данзанравжаагийн мэндэлсний 220 жилийн ойн хүрээнд “Эгшиглэнт говь” сумдын соёлын өдрүүдийг 05 дугаар сарын 06-ны өдрөөс 06 дугаар сарын 17-ны өдрийг хүртэл зохион байгуулсан. Энэхүү арга хэмжээ нь орон нутгийн онцлогийг илтгэсэн, өвлөн уламжлагдаж үлдсэн язгуур урлагийн бүтээл, Говийн V ноён хутагт Данзанравжаагийн бүтээл туурвил, гар урлал, соёлын бүтээлч үйлдвэрлэгчдийн үзэсгэлэн худалдаа, нутгийн зөвлөлийн уулзалт зэргийг багтаасан олон талт арга хэмжээг батлагдсан хуваарийн дагуу явууллаа.

Өргөн сумын соёлын өдөр

Өргөн сумын “Эгшиглэнт говь” соёлын өдөр нээлтийн үйл ажиллагаагаа аймгийн төв талбайд төрийн албан хаагчид, сумын болон аймгийн алдарт уяачид, малчид, монцементийн албан хаагчдыг оролцуулан жагсаж нутгийн зөвлөлийн уулзалт болон урлагийн тоглолт, гар урлал, соёлын бүтээлч үйлдвэрлэгчдийн бүтээлээр үзэсгэлэн худалдаа зохион байгуулж соёлын өдөрт 360 гаруй иргэд оролцсон.



Сайхандулаан сум соёлын өдөр

Сайхандулаан сум “Эгшиглэнт говь” соёлын өдөр аймгийн төв талбайд флаш моб, “Сайхан нутгийн бахархал” үзэсгэлэн худалдааг Музей сургалт судалгааны төвд, “Нутаг шүтээн Сайхандулаан” урлагийн тоглолтыг аймгийн иргэд болон нутгийн түмэндээ толилуулсан.



Улаанбадрах сумын соёлын өдөр

Улаанбадрах сумын гар урлал, соёлын бүтээлч үйлдвэрлэлийн үзэсгэлэн худалдаа бусад сумдаас онцлог байсан бөгөөд Музей сургалт судалгааны төвийн дэргэд нүүдэлчин соёл, уламжлалыг харуулсан монгол гэр барьж ардын уламжлалт хоол хүнсээр зочид төлөөлөгчдөө дайлсан. Улаанбадрах сумын урлагийн тоглолтыг 360 гаруй иргэд үзсэн.



Хатанбулаг сумын соёлын өдөр

Хатанбулаг сумын Сулинхээрийн заставын цэргийн анги аймгийн төв талбайд үзүүлбэр үзүүлэн, жагсаал хийж соёлын өдрийн нээлтийн үйл ажиллагааг эхлүүлсэн. Хатанбулаг сум Музей сургалт судалгааны төвд өвлөн уламжлагчдын гар урлалын бүтээлүүд, уламжлалт хоол хүнс, гэрэл зураг, уран баримал, модон эдлэлээр үзэсгэлэн худалдаа зохион байгуулсан. Хатанбулаг сумын урлагийн тоглолтыг цэгцтэй, гүйцэтгэл сайтай, олон нийтийг хамарсан, ардын авьяастнууд олонтой, шинэ содон үзүүлбэрийг толилуулсан сайхан тоглолт үзүүллээ гэж шүүгчид сэтгэгдэл өндөртэй байлаа.



Хөвсгөл сумын соёлын өдөр

Хөвсгөл сум Музей сургалт судалгааны гадна талбайд сумынхаа соёлын өдрийг нээлээ. Гар урлал, соёлын бүтээлч үйлдвэрлэлийн үзэсгэлэн худалдаагаар суран эдлэл, эсгий урлал, модон эдлэл, 9 хөлт цагаан тугыг дэлгэн үзүүллээ. Хөвсгөл сумын “Хутагтын нутгийн үлэмж төгөлдөр аялгуу” урлагийн тоглолтод говийн IX ноён хутагт уригдан ирсэн.



өдөр

Эрдэнэ сумын соёлын



Эрдэнэ сумын соёлын өдөр аймгийн төв талбайд сум, аймгийн алдарт уяачид, малчид, төрийн албан хаагчид, болон цэргийн ангийн жагсаал, 108 ээжийн цацал өргөх ёслол, хүндэтгэлийн ажлаар эхэлсэн. Эрдэнэ сумын гар урлал, соёлын бүтээлч үйлдвэрлэгчдийн 70 гаруй төрлийн бүтээлүүдийг дэлгэн үзүүллээ. “Элбэг нутгийн өлгий Эрдэнэ нутгийн дуулал” урлагийн тоглолтыг 350 гаруй үзэгч үзсэн.



“Эгшиглэнт говь” сумдын соёлын өдөрт 14 сумын 1000 гаруй ардын авьяастнууд, гар урлал, соёлын бүтээлч үйлдвэрлэгчид оролцож, урлагийн тоглолт болон гар урлагийн үзэсгэлэн худалдааг танхимаар 5000 гаруй хүн, шууд дамжуулалтаар 100,000 гаруй хүн үзсэн.



“Эгшиглэнт говь” сумдын соёлын өдрүүдийн хаалтын арга хэмжээг шилдгийн шилдгүүдээ тодруулан “Соёлын сэргэлт-2023” аяны нээлтийг тохиолдуулан 6-р сарын 19 ны өдөр “Эгшиглэнт говь-2023” гала тоглолт зохион байгуулж 162 ардын авьяастан оролцож танхимаар 500 гаруй хүн, шууд дамжуулалтаар 10,000 гаруй хүн үзсэн.



“Эгшиглэнт говь” сумдын соёлын өдрүүдийн шагналт байрууд:

Тэргүүн байр: Хатанбулаг сум-5 сая₮ өргөмжлөл, батламж

Дэд байр: Эрдэнэ сум-4 сая₮ өргөмжлөл, батламж

Гутгаар байр: Замын-үүд сум-3 сая₮ өргөмжлөл, батламж

Тусгай байр: Улаанбадрах сум-1 сая₮ өргөмжлөл, батламж

Тусгай байр: Хөвсгөл сум-1 сая₮ өргөмжлөл, батламж тус тус гардууллаа.

Аймгийн Засаг даргын А/331 тоот захирамжаар 18,760,000₮-ийг өргөмжлөл, шагналт байр болон шүүгчийн урамшуулалд зарцуулсан. “Эгшиглэнт говь” гала тоглолтын үеэр Соёл, урлагийн газрын нэрэмжит шагналаар Дэлгэрэх сум-500,0₮, Саран хөхөө театрын нэрэмжит шагналаар Зүүнбаян сумын Соёлын төв ордон-500,0₮, Музей сургалт судалгааны төвийн нэрэмжит шагналаар Өргөн сум-100,0₮ гардууллаа. Мөн Соёлын биет бус өвийг



өвлөн уламжлагчдийг урамшуулсан. Өвлөн уламжлагчдын тоо-50

Аймгийн Засаг даргын Тамгын газар, Соёл Урлагийн газраас санаачлан “Нээлттэй Дорноговь” зорилтот жил, Говийн Ноён хутагт Данзанравжаагийн мэлмий гийсний 220 жилийн ой тохиолдуулан уламжлал болгон зохион байгуулдаг Олон Улсын эрдэм шинжилгээний VI хурлыг “НОЁН ХУТАГТЫН ӨВ: ӨНГӨРСӨН, ОДОО, ИРЭЭДҮЙ” нэрийн дор 2023 оны 06-р сарын 09-ний өдөр Чингис Хаан үндэсний музейд амжилттай зохион байгууллаа. Эрдэм шинжилгээний хурлын зорилго нь говийн ноён хутагт судлалд эрдэмтэн, судлаачдын анхаарлыг хандуулах, судалгааны сүүлийн үеийн үр дүнг хэлэлцүүлэх, хамтын ажиллагааг хөгжүүлэх, Ноён хутагтын өвийн үнэ цэнэ, ач холбогдлыг тодруулах, аялал жуучлал, орон нутгийн хөгжилд бодит хувь нэмэр оруулахад орших бөгөөд хурлын нээлтэнд УИХ гишүүн Б. Дэлгэрсайхан, Т. Энхтүвшин, СУИС-ын Соёл урлаг судлалын хүрээлэнгийн захирал доктор (Sc.D), профессор Ч. Алтанцэцэг нар оролцож нээлтийн үг хэллээ. Тус хуралд Монгол, Орос, Хятад улсын 32 эрдэмтэн судлаачдын илтгэл хэлэлцүүлэгдэж Шинжлэх Ухааны эрдэмтэн багш нар, нутгийн алдартнууд Монгол Улсын Ардын Жүжигчин Г. Равдан, Монгол Улсын Төрийн Шагналт зохиолч Ш. Гүрбазар, Монгол Улсын Ардын Уран Зохиолч

Б. Догмид зэрэг 160 гаруй зочид төлөөлөгчид оролцлоо. Хуралд оролцсон илтгэгчдэд Аймгийн Засаг дарга О. Батжаргал хүндэтгэл үзүүлж илтгэгч тус бүрт талархал, мөнгөн урамшуулал гардууллаа. Гадаадын эрдэмтэн судлаачид Данзанравжааг Монголын нийгмийн амьдралыг шинэчлэгч, урлаг соёлын гарамгай зүтгэлтэн, их соён гэгээрүүлэгч



хэмээн судалгааныхаа бүтээлд олонтаа дурьдаж, ийм богино наслахдаа амьдарсан хугацаандаа амжихааргүй их зүйлийг бүтээжээ хэмээн гайхан биширдэг билээ. 2006 онд ЮНЕСКО “Данзанравжаагийн жанч халсны 150 жил” гэж тэмдэглэх шийд гаргаж, шүлгүүдийг нь англи хэл дээр орчуулсан билээ. Энэ арга хэмжээг аймгийн Засаг даргын А/373-р захирамжаар 18300,000 төгрөгөөр санхүүжүүллээ.

"Соёлын сэргэлт-2023"-ыг Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музейтэй хамтран 14 сумын 12100 хүнд соёлын үйлчилгээг үзүүллээ. “Золгоё доо”, “Өвгөдийн захиас”, “Ээж минь” язгуур урлагийн тоглолтыг "Алтай" хамтлаг, “Соёлын бүтээлч үйлдвэрлэл” Дорноговь аймгийн ЖДҮ-ийн үзэсгэлэн худалдаа “Хайрцагтай музей” боловсролын хөтөлбөр, “Дорноговь аймгийн гар урлал, урчуудын үзэсгэлэн” WR үзэсгэлэн “Монголын нэг өдөр” “Торгонд амилсан шүтээн урлаг” нүүдлийн үзэсгэлэн “Барлах урлаг” боловсролын хөтөлбөрүүдээр аймгийн 14 сумдыг хамруулан иргэдэд үйлчиллээ.

“Соёлын сэргэлт-2023” аяны нээлтийн хөтөлбөрт Ардын уран зохиолч Балжирын Догмидыг алдаршуулах “Санаж сарвайх нутаг ус минь уу” уншигч зохиолчдын уулзалт хийж Б.Догмидын уран дууны болон богино өгүүллэгийн бүтээлүүдийн дээжсээс ардын уран зохиолч Равдан, СГЗ Гүрбазар, уран уншигч Энхдөл зэрэг уран бүтээлчид болон Саран Хөхөө театрын дуучид, хөгжимчид 300 гаруй үзэгчдэд сонирхууллаа.



МУЗЕЙ СУРГАЛТ СУДАЛГААНЫ ТӨВ

Зорилтот арга хэмжээний хэрэгжилтийн явц:

- “Музейн үзүүлэгийн танхимаар 156 том хүн, 732 хүүхэд, 24 гадаад, нийт 912 хүнд үйлчилгээ үзүүлсэн.
- Өргөн, сайхандулаан, Улаанбадрах, Хатанбулаг, Хөвсгөл, Эрдэнэ сумдын соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгч иргэдийн үзэсгэлэн худалдаа зохион байгуулагдсан.
- Олон Улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан аймгийн Төв номын сантай хамтран хүүхдүүдийн дунд буухиа тэмцээн, гар зургийн уралдааныг тус тус зохион байгууллаа. Энэ үеэр хүүхдийн гар зургийн үзэсгэлэн, том номын үзэсгэлэн дэлгэсэн. Тэмцээн уралдаанд оролцож байр эзэлсэн 15 хүүхдэд аймгийн Засаг даргын Тамгын газрын гарын бэлгийг гардуулсан.



- “Ноён хутагтын өв-Өнөө, Одоо, Ирээдүй” Олон улсын эрдэм шинжилгээний хурал зохион байгуулагдсан.



“Соёлын сэргэлт-2023” аяны хүрээнд аймгийн үзэсгэлэнгийн танхимд “Гэгээн суварга” нүүдлийн үзэсгэлэн зохион байгуулав .

“Соёлын сэргэлт-2023” аяны хүрээнд аймгийн төв талбайд музейн үйл ажиллагааны иргэдэд 80 ширхэг сэтгүүл, боршур тараасан. Хүүхдүүдэд “Монгол гэр” Боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлэв.

“Соёлын сэргэлт” аяны хүрээнд соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчдийн үзэсгэлэн худалдаа зохион байгуулсан. Үзэсгэлэн худалдаанд соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгч 3 аж ахуй нэгж, 10 иргэн оролцсон.

САРАН ХӨХӨӨ ТЕАТР

Зорилтот арга хэмжээний хүрээнд:

- 6 дугаар сарын байдлаар тус театр нь **17** төрлийн үйл ажиллагааг тухайн холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулан ажилласан. Энэ сарын байдлаар үзвэр болон урлагийн үйлчилгээг **7857** үзэгчдэд хүргэж ажилласан
- “Эх үрсийн баяр”-ыг тохиолдуулан театрын дэргэдэх гэр бүлийн зөвлөлөөс байгууллагын ажилчид, уран бүтээлчдийн хүүхдүүдэд хүндэтгэл үзүүлэн гарын бэлэг

гардуулсан. Мөн "Шидэт бэлгийн эрэлд" 1 цагийн хүүхдийн жүжиг тоглож нийт 250 гаруй хүүхэд багачуудад үзсэн.

- Говийн 5 дугаар ноён хутагт Дулдуйтын Данзанравжаагийн мэлмий гийсний 220 жилийн ойд зориулан шинээр туурвиж буй бүс нутгийн онцолгийг харуулсан. Төрийн соёрхолт, СГЗ Ш.Гүрбазарын зохиол, Э.Идэрболдын найруулга "Гэтэлгэх мөр" хөгжимт драмын жүжгийг Хамарын хийдэд 3000 гаруй жуулчид, нутгийн иргэдэд тоглосон.
- Монгол Улсын урт хугацааны "Алсын хараа 2050" хөгжлийн бодлогыг хүрээнд Соёлын сэргэлт-2023 нээлтийн арга хэмжээнд 14-н сумдын иргэдэд сурталчлан таниулах ажлын хэсэгт театрын 6 уран бүтээлч оролцож урлаг соёлоор иргэдэд үйлчилсэн.
- Төрийн албаны тухай хууль тогтоомж, төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг олон нийтэд сурталчлах сургалтад театрын 45 албан хаагч хамрагдсан.
- **Цаг үеийн ажлын тайлан:**
- МУСТА П.Жимсээ, МУСТА А.Түмэн-Өлзий нарын эх үрсийн баярт зориулсан "Ижийгээ дуулъя" хамтарсан тоглолтыг 190 хүн үзсэн.
- Сайншанд сумын Ерөнхий боловсролын лаборатори 2-р сургуулийн Говийн уянга бүжгийн хамтлагийн "Бүжгээр хөглөгдсөн сурагч нас минь" тоглолт театрын тайзнаа тоглогдсон.
- "Нарны алтан онис" ТББайгууллагын үйл ажиллагаа театрын үзвэрийн танхимд зохион байгуулагдсан.
- Дорноговь аймгийн Засаг даргын тамгын газар, Онцгой байдлын газраас зохион байгуулсан "Гамшгаас хамгаалах удирдах бүрэлдэхүүний сургалтад сургалт, сурталчилгаа хариуцсан баг хамрагдсан.
- Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга нарын хүлээн авалтад театрын 15 уран бүтээлч оролцсон.
- Замын -үүд сумын төмөр замын зөрлөгт Соёмбо тавих ёслолд тус театрын 8 уран бүтээлч оролцсон.
- 2023-оны Зүүн бүсийн ахмадын наадам театрын тайзнаа тоглогдож 200 гаруй үзэгч хүрэлцэн ирсэн.

ТӨВ НОМЫН САН

Зорилтот арга хэмжээний хэрэгжилтийн явц:

- Тавдугаар сард Төв номын сангаар 944 уншигч ирж, танхимаар 117 уншигчид үйлчилж, гэрээр 185 ном олгож, 76 номыг зөөврөөр хүүхдийн уншлагын танхимд олгосон. Төв номын сангийн "Аз жаргалын өргөө"-нд 70 хүүхэд зочилсон.
- Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан **Музей сургалт судалгааны төв** талбайд хүүхэд багачуудын баярт зориулан баярын орчин бүрдүүлж 3D ном, Том номыг толилуулж, **нийт** 200 гаруй хүүхэд, эцэг эхчүүд үзэж сонирхов.
- Говийн ноён хутагт Д.Данзанравжаагийн мэлмий гийсний 220 жилийн ойг угтан Улаанбаатар хотод "Ноён хутагтын өв: Өнгөрсөн, Одоо, Ирээдүй" сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний 6-р хуралд 1 албан хаагч төлөөлөн оролцсон.
- Төрийн албаны зөвлөлөөс "Монгол мандсан шалтгаан" онлайн цахим сургалтад 7 албан хаагч хамрагдсан.
- МҮНС-аас ирсэн мэргэжилтэнүүд номын сангийн ажилчдыг чадавжуулах сургалтад 7 албан хаагч хамрагдсан
- "Соёлын сэргэлт-2023" үйл ажиллагаанд Монгол улсын төрийн соёрхолт, Ардын уран зохиолч, соёлын гавьяат зүтгэлтэн Б.Догмидын "Санаж сарвайх нутаг, ус мину" уулзалт арга хэмжээг зохион байгуулж, нийт 500 гаруй иргэн хүрэлцэн ирж сонирхсон.
- "Соёлын сэргэлт-2023" нээлтийн үйл ажиллагаанд хүрэлцэн ирсэн үзэгчдийн урилгын бар код уншуулах ажилд 2 албан хаагч хамрагдсан.

- Соёлын дэд сайд М.Батбаяр “Эртэч өглөө” номтой хөтөлбөрөөр соёлын салбарын залуустай уулзалт хийж, Их хаадын тамганы талаарх сонирхолтой мэдээлэл сонсон энэхүү үйл ажиллагаанд 9 албан хаагч хамрагдсан
- “Төрийн албаны шинэтгэл ба төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль” танилцуулга сэдэвт сургалтад 7 албан хаагч хамрагдсан.

Америкийн соёл мэдээллийн төвийн 6-р сарын тайлан

Үйлчлүүлэгчдийн тоо	401
Зохион байгуулагдсан хөтөлбөрүүд	11
Хөтөлбөт оролцсон иргэдийн тоо	309
Уншсан номын тоо	16

Хөтөлбөрүүдийн нэрс	Зохион байгуулсан	Үйл ажиллагаа явагдсан тоо	Ирэгсдийн тоо
Speaking club /Ярианы клуб/	American corner Dornogovi	5	52
Let's Sing /Хамтдаа дуулцаа/	American corner Dornogovi	4	36
Spelling bee /Үсэглэгч зөгий/	American corner Dornogovi	4	48
Movie time /Киноны цаг/	American corner Dornogovi	4	32
ABC English /Суурьгүй анхан шатны англи хэлний сургалт/	American corner Dornogovi	4	31

Хүүхдийн баяраар эцэг эхчүүдэд брошур тараав.

- 6-р сарын 1-ны өдөр манай төвд явагддаг “Student Internship Program” буюу дадлагажуулах хөтөлбөрийн сурагчид өөрсдийн гараар хийсэн **100ш** брошураа тарааж, мэдээлэл олгов. Төвөө олон нийтэд таниулах зорилготой байсан бөгөөд эцэг эхчүүд рүү илүү чиглэж мэдээлэл өгөхийг зорьсон.
- **“Mysterio” хөтөлбөр.**
- Mesterio хөтөлбөр нь тусгайлан сонгосон сэдэв дээр сонгогдсон дадлагажигч нарт илтгэл тавьж үүний дараа мэтгэлцээний сэдэв өгөгдөн илтгэгч болоод үзэгч сонсогчдын хамтаар мэтгэлцээн хийдэг хөтөлбөр юм. Энэхүү хөтөлбөр 4 сэдвийн хүрээнд 2 долоо хоногийн хугацаанд явагдсан. 1 удаагийн хөтөлбөр ойролцоогоор 10-12 оролцогчтой явагдсан ба оролцогч иргэд, хүүхдүүд бусдад өөрийн санаагаа зөв илэрхийлэх, хүнтэй харьцах чадварыг нэмэгдүүлэх зорилготой.



“Соёлын сэргэлт 2023”

- Монгол улсын засгийн газар, Соёлын яамнаас хэрэгжүүлсэн “Соёлын сэргэлт-2023” аян Дорноговь аймагт 6-р сарын 19-ны өдөр зохион байгуулагдсан. Америкийн соёл мэдээллийн төв нь номын сангийн хамтаар “Ном болон бүтээл”-ийн үзэсгэлэн **гарган** зочилсон иргэдэд төвийн талаар мэдээлэл олгосон.



- 4.Хоггүй тоглоомын талбай.**
- Сайншанд сумын 1-р багийн ажлын албанаас 6-р сарын 21-ны өдрийг “Хоггүй тоглоомын талбай” өдөр болгон зохион байгуулсан. Энэхүү ажилд манай төвийн хөтөлбөрийн ажилчид болон Junior Empowering Program-ын төгсөгчид хамтран оролцов. Тус ажлын хүрээнд Сайншанд сумын 1-р 60 айлын зүүн талд байрлалтай Тэмээтэй талбайг цэвэрлэж, цементэн шалыг угааж, хамтдаа цэцгийн үр суулгасан.



- 5.Open Mic Night.**
- Америкийн Соёл Мэдээллийн төв нь Сайншанд сумын иргэдийн **аль** хэдийн танил болсон Sainshand Cover-ийн хамт олонтой хамтран ажилласан. 6-р сарын 21-ны үдэш Sainshand Cover-н хамт олны зохион байгуулдаг Open Mic хэмээх залуусын дунд явагддаг дууны хөтөлбөрт бид бүхэн очиж мэдээлэл хүргэх зорилготой байв. Тус үйл ажиллагаанд манай зүгээс хүүхдүүдээс Америк улстай холбоотой асуулт асууж зөв хариулсан оролцогчдод өөрсдийн гараар хийсэн аяган бялуу болон манай төвийн нэр бүхий цаасан наалт брошур зэргийг бэлэглэв.



6.Америкийн элчин сайдын яамнаас сайн дурын хөтөлбөрийн багшийг урьж хамтран ажиллав. 6-р сарын 21-нээс 7-р сарын 1-ны хооронд манай төвд Америкийн элчин сайдын яамны Фулбрайт хөтөлбөрийн англи хэлний туслах багш хатагтай Wen Wendt зочилон ажиллаж, үйлчлүүлэгч иргэдэд олон төрлийн англи хэл болоод, Америк улстай холбоотой мэдээ мэдээллүүдийг хүргэсэн. Түүнээс дурьдвал:

- Ахлах ангийн хүүхдүүд болон залуучуудыг хамарсан АНУ-д хэрхэн суралцах вэ? лекц
- Багачуудад зориулсан англи хэл дээрх тоглоомын цаг, бүх насныханд зориулсан ярианы клуб зэрэг явагдав.



БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ЧИГЛЭЛЭЭР:

- Биеийн тамир, спортын газрын дэргэдэх спортын секц дугуйлан хэвийн хичээллэж байна.
- Биеийн тамир, спортын улсын хорооноос “Цаг гаргая” биеийн тамирын арга хэмжээг 04 дүгээр сарын 03-наас 06 дугаар сарын 24-ний өдрийг хүртэл улс орон даяар зохион байгууллаа. Биеийн тамир, спортын газар нь “Цаг гаргая” аянд оролцох албан байгууллагуудын хуваарийг шинэчлэн баталж, шугаман бүжиг, алхалт, гүйлт гэсэн төрлөөр 7 хоног бүрийн Баасан, Бямба, Ням гарагуудад аянг зохион байгуулж ажиллалаа. Аянд аймгийн хэмжээнд давхардсан тоогоор 10700 иргэд хамрагдсан байна. “Цаг гаргая” биеийн тамирын арга хэмжээний тайланг 06 дугаар сарын 28-ны өдөр Биеийн тамир, спортын улсын хорооруу хүргүүлж ажиллалаа.
- Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэс, БТСГ, аймгийн Нийтийн бүжгийн холбоо хамтран 05 дугаар сарын 29-нөөс 06 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл аймгийн ард иргэдийн дунд Нийтийн бүжгийн ахисан шатны сургалтыг үнэ төлбөргүй зохион байгуулж, уг сургалтад нийт 200 гаруй иргэд хамрагдсан.

- Биеийн тамир, спортын улсын хорооноос 05 дугаар сарын 30-ны өдөр байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудитыг хийж, зөвлөмж өгч ажиллалаа.
- Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан Биеийн тамир, спортын газраас 06 дугаар сарын 01-ний өдөр 3х3 сагсан бөмбөгийн болон мини волейболын тэмцээнийг зохион байгуулж ажиллалаа.
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлагаар хэрэгжүүлж буй “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний хүрээнд аймгийн Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн газар, Биеийн тамир, спортын газар хамтран 06 дугаар сарын 02-ны өдөр “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг зохион байгууллаа. Уг нээлттэй хаалганы өдөрлөгөөр сагсан бөмбөг, волейбол, жүдо бөх, чөлөөт бөх, шатар, шугаман бүжиг, ажлын байрны дасгал, хийн дасгал, фитнесс, спиннингийн ард иргэдэд сурталчилан таниулан ажиллалаа.
- Монгол Улсын сайд, олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хорооны дарга, Дорноговь аймгийн Засаг дарга нарын Биеийн тамир, спортын салбарт 2023 онд хамтран ажиллах гэрээний эхний хагас жилийн хэрэгжилтийг 06 дугаар сарын 05-ны өдөр аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэст хүргүүлэв.
- Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх “Стратегийн команд штабын сургууль” зохион байгуулагдахтай холбогдуулан Биеийн тамир, спортын газар 2023 оны 06 дугаар сарын 06-ны өдөр аймгийн Онцгой байдлын газраас мэдээлэл авч ажиллав. 06 дугаар сарын 08-ны өдрийн 16.00 цагт зарлан мэдээллийн дохиогоор аюулгүйн цэгт нүүн шилжих дадлага сургуулилалт хийж, тайланг аймгийн Онцгой байдлын газарт хүргүүлэв.
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж буй “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний хүрээнд Дорноговь аймгийн Явган алхалтын холбоо, Замын-Үүд сумын Засаг даргын Тамгын газар, Хилийн цэргийн 0108-р анги, Биеийн тамир, спортын газартай хамтран Говийн ноён хутагт Данзанравжаагийн мэлмий гийсний 220 жилийн ойг угтсан “Дорнын говь-Хутагтын нутгаар-2023” уртын алхалт 06 дугаар сарын 04-08-ны өдрүүдэд зохион байгуулагдлаа. Энэхүү уртын алхалтад 11 тамирчид Замын-Үүд сумаас Сайншанд сум хүртэл 220 км-ийг явганаар туулсан байна.
- U-14 волейболын аймгийн аварга шалгаруулах тэмцээн 06 дугаар сарын 10-11-ний өдрүүдэд Спортын ордонд болов.
- Дорноговь аймгийн Улаанбадрах сумыг сурталчилах өдөрлөгт зориулсан үндэсний бөхийн барилдаан 06 дугаар сарын 10-ны өдөр Спорт цогцолборт болов.
- Дорноговь аймгийн Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2023 оны хагас жилийн хэрэгжилтийг 06 дугаар сарын 12-ны өдөр, аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөний хагас жилийн хэрэгжилтийг 06 дугаар сарын 19-ний өдөр, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн эхний хагас жилийн хэрэгжилтийг 06 дугаар сарын 30-ны өдөр тус тус тайлагнан ажиллав.
- Улсын Их хурал, Засгийн газраас төрийн үйлчилгээний албан хаагчдын цалинг 7 дугаар сараас нэмэгдүүлэхтэй холбоотойгоор Биеийн тамир, спортын улсын хорооруу байгууллагын албан хаагчдын судалгааг гарган, албан тушаалын тодорхойлолтын хамт 06 дугаар сарын 13-ны өдөр хүргүүлж ажиллав.
- Биеийн тамир, спортын улсын хорооруу “Бие бялдрын түвшин тогтоох сорил”-ын дүн мэдээг шивж хүргүүлэв.
- Биеийн тамир, спортын улсын хорооруу “Эерэг хандлага-Эрүүл нийгэм” аяны төлөвлөгөөний явцын тайланг 06 дугаар сарын 15-ны өдөр хүргүүлэв. Уг аянд байгууллагын албан хаагчид болон спортын секц дугуйлангийн хүүхдүүд, дасгалжуулагч нар хамрагдан ажиллаж байна.
- Сайншанд сумын Засаг даргын Тамгын газраас 2023 оны 06 дугаар сарын 17-ны өдөр зохион байгуулсан “Сайншанд марафон 2023” арга хэмжээний шүүгчээр байгууллагын

биеийн тамирын арга зүйч, дасгалжуулагч нар ажиллав. Марафонд 200 гаруй иргэд хамрагдсан байна.

- Байгууллагын 5 албан хаагч Соёмбо цогцолборт 06 дугаар сарын 16-ны өдөр зохион байгуулагдсан “Цайны соёлын ертөнц” цайны соёлын үзэсгэлэнгийн нээлтэд оролцов.
- Сайншанд сум байгуулагдсаны 62 жилийн ойн хүрээнд сумын цол олгох үндэсний бөхийн барилдаан 06 дугаар сарын 20-ны өдөр Спорт цогцолборт болов. Сумын цол олгох үндэсний бөхийн барилдаанд нийт 64 бөх оролцсон байна.
- Говийн бүсийн ахмадын аварга шалгаруулах софт волейболын тэмцээн Спортын ордонд болон цэнгэлдэх хүрээлэнд 06 дугаар сарын 22-ны өдөр болов. Тус тэмцээнд Дорноговь, Говьсүмбэр, Дундговь, Өмнөговь гэсэн 4 аймгийн нийт 24 баг тамирчид оролцов.

Эмэгтэй 100 метрийн гүйлтийн төрөлд:

- 1-р байранд Дорноговь
- 2-р байранд Говьсүмбэр
- 3-р байранд Дундговь

Эрэгтэй 100 метрийн гүйлтийн төрөлд:

- 1-р байранд Өмнөговь
- 2-р байранд Говьсүмбэр
- 3-р байранд Дундговь аймгууд шалгарчээ.

Нийлбэр дүнгээр:

- 1-р байранд Говьсүмбэр
- 2-р байранд Дорноговь
- 3-р байранд Дундговь аймаг тус тус шалгарлаа.


- Нийтийн бүжгийн спортын VII их наадам 06 дугаар сарын 23-25-ны өдрүүдэд Спорт цогцолборт зохион байгуулагдаж, байгууллагын зүгээс Дорноговь аймгийн баг тамирчдад бэлтгэл сургуулилт хийхэд заалаар ханган дэмжлэг үзүүлэн ажиллалаа
- Байгууллагын нийт албан хаагчид 06 дугаар сарын 27-ны өдөр нийтийн хуваарьт талбайг цэвэрлэх ажлыг хийж гүйцэтгэн, цэвэрлэгээ хийсэн тайланг Сайншанд сумын 1 дүгээр багийн ажлын алба руу хүргүүлж ажиллав.
- Баянхонгор аймагт 06 дугаар сарын 19-29-ний өдрүүдэд зохион байгуулагдсан Монголын хүүхдийн спортын зуны VII их наадамд Дорноговь аймгийн баг тамирчид чөлөөт бөх, жүдо бөх, самбо бөх, дугуй, бокс, шатар, даам, гандбол гэсэн спортын 8 төрлөөр 71 тамирчин амжилттай оролцсоноос: Чөлөөт бөхийн төрөлд спортын мастер С.Сайнбаяр, спортын мастер А.Зоригтбаатар дасгалжуулагчтай, тамирчин Э.Отгонжаргал 49 кг-ийн жинд хүрэл медаль, Жүдо бөхийн төрөлд олон улсын хэмжээний мастер М.Сугар дасгалжуулагчтай, тамирчин Б.Сарангоо -40 кг-ийн жинд хүрэл медаль, Боксын төрөлд спортын мастер Г.Баасан, спортын мастер Ж.Баяр-Отгон дасгалжуулагчтай, тамирчин Д.Тэнгис +63 кг жинд алтан медаль, тамирчин Н.Анужин 44 кг жинд мөнгөн медаль, тамирчин Г.Наран-Эрдэнэ 46 кг жинд мөнгөн медаль, тамирчин Э.Эрдэнэцэцэг +57 кг жинд мөнгөн медаль, тамирчин О.Мөнх-Эрдэнэ 46 кг жинд хүрэл медаль, тамирчин Б.Сүхбат 50 кг жинд хүрэл медаль, тамирчин Г.Маралжин 52 кг жинд хүрэл медаль тус тус авч багийн дүнгээр 3-р байранд, Гандболын төрөлд спортын мастер Б.Баяржаргал дасгалжуулагчтай, П.Янжиндулам ахлагчтай охидын баг алтан медаль, спортын мастер М.Балжинням дасгалжуулагчтай, А.Лувсан ахлагчтай хөвгүүдийн баг хүрэл медаль хүртсэн амжилт үзүүллээ.
- Монголын хүүхдийн спортын зуны VII их наадамд Дорноговь аймгийн баг тамирчид нийт 11 медаль хүртсэн байна.
- БНХАУ-ын Элчин сайдын яам, Дорноговь аймаг хоорондын хамтын ажиллагааны хүрээнд Замын-Үүд дэх консулын газраас зохион байгуулж буй “Цайны соёлын ертөнц”

- Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн ажлын хэсэг 06 дугаар сарын 28-29-ний өдрүүдэд Дорноговь аймагт ажилласан бөгөөд Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн сургалтыг зохион байгуулав. Уг сургалтад байгууллагын албан хаагчид Саран хөхөө театрт 06 дугаар сарын 29-ний өдөр хамрагдав.

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭ:

- | № | Үзүүлэлт | 2022.06 сар | 2023.06 сар | Өмнөх оны мөн үетэй харьцуулсан үр дүн /тоогоор/ | |
|---|-----------------------|-------------|-------------|--|--|
| 1 | Ажил хайгч | 224 | 558 | +334 | |
| 2 | Ажилд зуучлал | 375 | 263 | -112 | |
| 3 | Ажлын байрны захиалга | 485 | 384 | -101 | |
| 4 | Шинэ ажлын байр | 171 | 249 | +78 | |

- [illegible]



1. “АЖЛЫН ГАРАА - НУТГИЙН ХӨГЖИЛ” арга хэмжээг 06 сарын 27-нд зохион байгуулахаар төлөвлөж хөтөлбөр, төлөвлөгөөг гарган, төлөвлөгөөний дагуу бэлтгэл ажлын хэрэгжилтийг ханган ажиллалаа. Үүнд:


- Штрок мэдээллийг орон нутгийн Dtv телевиз, байгууллагын болон багуудын пэйж хаягаар иргэдэд хүргэн ажиллаж
- Арга хэмжээний талаарх мэдээллийг 6 сарын 21-нд Сайншанд сумын иргэний танхимд нийт 8-н багийн ажлын албаны 31 албан хаагчдад мэдээлэл хүргэж ажилласан
- Сумдын Засаг дарга нарт аймгийн ЗДТГ-ын даргын албан тоот хүргүүлэхээр албан бичгийн төслийг бэлтгэн аймгийн ЗДТГ-ын НБХ-т хүргүүлсэн.
- Аймгууд болон нийслэлийн ХХҮГ-т орон нутгийн залуучуудад мэдээлэл түгээж хамтран ажиллах тухай Газрын даргын 2023 оны 06 сарын 23-ны 293, 294 дугаартай албан тоотыг хүргүүлэн ажиллалаа.
- Хамтран ажилладаг 100 гаруй аж ахуй нэгж байгууллагатай холбогдож, 75 байгууллагын 527 ажлын байрны захиалгыг шинэчлэн бүртгэлээ. Арга хэмжээнд 31 ААНБ биечлэн ирж ажлын байраа танилцуулан хамрагдахаар болоод байна.
- Сайн туршлагаа хуваалцах 2, батламж гардуулах 16 төгсөгч залуучуудтай холбогдож, мэдээлэл өглөө.
- Сайншанд, Замын-Үүд сумын 460 гаруй төгсөгч оюутан залуучуудын судалгааг гарган тэдгээртэй холбогдох арга хэмжээг авч ажилласнаас холбогдож буй 100 гаруй төгсөгч оюутан залуучуудад мэдээлэл өгсөн.
- Бусад бэлтгэл ажлыг ханган ажилласан.



Дорноговь аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газар

1d · 🌐

Ажил идэвхтэй хайгч залуус, шинээр их дээд сургууль төгсөж буй оюутан залуус та бүхн
"АЖЛЫН ГАРАА-НУТГИЙН ХӨГЖИЛ 2023" арга хэмжээнд хүрэлцэн ирэхийг урьж байна.
ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЛИЙГ 7052-2227 дугаараас лавлана уу.



ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГАА:

1. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭНИЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГАА: Тус үйл ажиллагааны санхүүгийн дэмжлэгт хамрагдсан 12 иргэнийг зээл олгосны дараах сургалтад хамрууллаа. Сургалтыг "Оюуны язгуур" ТББ-ын дэргэдэх сургалтын байгууллагатай гэрээлэн 06 сарын 06-07-ны өдрүүдэд зохион байгууллаа.
2. ХӨДӨЛМӨРТ БЭЛТГЭХ СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА:

- **Үйлдвэрлэл дээрх сургалтыг** “Багануур-Зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн Дорноговь аймаг дахь салбарын хүсэлтэд үндэслэн “Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨҮ-ийн дэргэдэх сургалтын төвтэй хамтран цахилгаанчин мэргэжлээр 06 сарын 26-наас эхлэн 15 иргэнийг хамруулан зохион байгуулж байна.
- **Санхүүгийн дэмжлэг олгосны дараах аж ахуй эрхлэлтийн сургалт:** Иргэн аж ахуй эрхлэгчид санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд хамрагдсан 15 иргэнийг тус сургалтад хамрууллаа. Сургалтыг “Оюуны язгуур” ТББ-ын дэргэдэх сургалтын байгууллагатай гэрээлэн 06 сарын 08-09-ны өдрүүдэд зохион байгууллаа.

3. ТҮР АЖЛЫН БАЙРЫГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГАА:

- **Мод тарих арга хэмжээнд** Сайншанд, Иххэт, Алтанширээ, Дэлгэрэх, Эрдэнэ сумдыг хамруулж, Сайншанд сум-31, Иххэт сум -10 , Алтанширээ сум-9, Дэлгэрэх сум-10, Эрдэнэ сум-10, нийт 70 иргэн
- **Нийтийг хамарсан ажил арга хэмжээнд** Өргөн, Мандах сумдыг хамруулж, Өргөн сум-5, Мандах сум-10, нийт 15 иргэний бичиг баримтыг хянан хүлээн авсан.

Үйл ажиллагаанд нийт 85 иргэнийг хамруулан түр ажлын байраар хангасан.

- **Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ:** Алтанширээ сумын ЗДТГ-т зөвлөх үйлчилгээ үзүүлэхээх хүсэлтээ ирүүлсэн 1 иргэний хүсэлт, мөн зөвлөх үйлчилгээ авах хэрэгцээ шаардлагаа тодорхойлж төсөл хүсэлтээ ирүүлсэн 2 байгууллагын хүсэлт төслийг хүлээн аваад байна.

4. САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА:

Гарааны бизнес эрхлэгч залуучуудад санхүүгийн дэмжлэг олгох буюу СТАРТ-АП арга хэмжээний бүртгэлийг 5 сарын 09-30-ныг дуустал хийхээр зар мэдээллийг түгээн ажилласан бөгөөд тус хугацаанд 13 иргэн бүртгүүлсэн тул нэмэлт бүртгэлийг хийх зар мэдээг 6 сарын 09- хүртэл, дахин сунгаж 6 сарын 28-ны өдрийг хүртэл явуулахаар байгууллагын пэйж хаяг, орон нутгийн DTV телевизээр олон нийтэд хүргэн ажиллаж байна.

Start-up залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сургалт арга хэмжээг 2023.06.30-2023.07.02-ныг дуустал хугацаанд Улаанбаатар хотын “Шинэ эхлэх цэг” ТББ-ын дэргэдэх сургалтын байгууллагатай хамтран зохион байгуулахаар гэрээ байгуулж, сургалтад хамрагдахаар бүртгүүлсэн 15 залуучуудад мэдээлэл хүргэж бэлтгэл байдлыг ханган ажиллаж байна.

 ДОРНОГОВЬ АЙМГИЙН ХӨДӨЛМӨР, ХАЛДЛАХИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР

 **StartUp**
2023 ДОРНОГОВЬ АЙМАГ

Шилдэг стартап залуу болон
залуучуудын багтм санхүүгийн
дэмжлэг олгох

УРАЛДААН

Шинэ технологи, инновац бүхий
шинэлэг санал, санаачлаг гаргаж, аж
ахуй эрхлэх төсөл боловсруулсан
шилдэг “Старт-Ап” залуу,
залуучуудын багийг шалгаруулж 10.0
сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг
олгоно.

Бүртгэлийн хугацаа:
2023.05.31-2023.06.09-нийг
дуустал

Дэлгэрэнгүй мэдээллийг ажлын
өдрүүдэд 7052-2227, 9905-1522
дугаараас авна уу.

ТӨСӨВ, САНХҮҮГИЙН ЧИГЛЭЛЭЭР

1. Үндсэн болон нэмэлт Төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ

ХЭДС болон Халамжийн сангийн 2023 оны 05-р сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээ гаргаж ХХҮЕГ-т цахимаар хүргүүлсэн.

Баянзүрх дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд иргэн Т.Цэнд-Аюушийг санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтөө хугацаандаа төлөөгүй гэж газрын даргын 2023 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 298 тоот албан бичгээр нэхэмжлэл гаргасан.

2. Орлого бүрдүүлэх, төвлөрүүлэлт хийх, зарлага санхүүжилт

2023 оны 06-р сарын 01-ний өдрөөс 26-ны өдрийн хугацаанд 70 иргэний 32,226,358 төгрөгийн зээлийн эргэн төлөлтийн орлого орсон байна. Мөн 4 иргэний 7,400,000 төгрөгийн зээл бүрэн төлөгдсөн.

2023 оны 06-р сарын 01-ний өдрөөс 26-ны өдрийн байдлаар ХЭДС 355,007,800 төгрөгийн санхүүжилт авч 142,891,000 төгрөгийн 24 гүйлгээ хийсэн.

ХЭДС-нд 2023 онд Хөгжлийн бэрхшээлтэй хүн ажилууллаагүйн төлбөр 130.0 сая төгрөг төвлөрүүлэхээс тайлант хугацаанд хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллууллаагүйн төлбөр 20,900,000 төгрөгийг 3 аж ахуй нэгж байгууллагаас төвлөрүүлсэн. Үүнд:

1. Бадрах энерги ХХК – 6,600,000 төгрөг

2. Мон цэмэнт ХХК – 11,000,000 төгрөг

3. Доншен газрын тос Монгол ХХК – 3,300,000 төгрөгийг тустус төвлөрүүлсэн бөгөөд ХХҮЕГ-т төвлөрүүлсэн. Бадрах энерги ХХК-ны 2-р улирлын нэхэмжлэлийг 2 иргэнээр бодож 3,300,000 төгрөгийг И-баримтад шивж илгээсэн.

3. Шилэн дансанд мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу 2023 оны 06-р сарын байдлаар ХЭДС 46 мэдээлэл оруулснаас 13 мэдээлэл хугацаа хоцорч байршуулсан байна. Халамжийн сан 58 мэдээлэл оруулснаас 9 мэдээлэл хугацаа хоцорч байршуулсан.

Шилэн дансны хөтлөлт, хэрэгжилтийг хангаж 5 дугаар сарын байдлаар хөдөлмөр эрхлэлт, халамжийн сангийн мэдээллэвэл зохих 87 мэдээллийг бүрэн байршуулсан.

БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА:1. Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт хамрагдсан иргэдийн зээлийн үлдэгдлийн мэдээллийг гарган эргэн төлөлтөд дүн шинжилгээ хийж, зээлээ хугацаандаа төлөхгүй байгаа иргэдтэй утсаар 1 бүрчлэн холбогдож хуваарийн дагуу

АВЛАГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ЖУРНАЛ

Тайлант хугацаа: 2023.01.01 - 2023.05.31										
№	Байгууллага	Аймаг, хот	Сум, дүүрэг	Данс	Огноо	Эхний үлдэгдэл	Кредит	Эцсийн үлдэгдэл 05.31	2022.12.31	Тайлбар 6.14
1	Өлзийжаргал ЕЮ70033105 <РД:ЕЮ70033105>			33705 - Хөгжлийн		1,000,000.00	-	1,000,000.00	1,000,000.00	төлөлт хийгээгүй
2	Өлзийтогоо			33705 - Хөгжлийн		(55,000.00)	-	(55,000.00)		илүү төлөлт
3	Адъяасүрэн М ЛБ88102404 <РД:ЛБ88102404>			33705 - Хөгжлийн		1,180,000.00	-	1,180,000.00	1,180,000.00	төлөлт хийгээгүй
4	Азжаргал Бямбаа ЕЕ88011602 <РД:ЕЕ88011602>			33705 - Хөгжлийн		1,468,000.00	-	1,468,000.00	1,468,000.00	төлөлт хийгээгүй
5	Алтанзул Оюунцэцэг ЕА82072113 <РД:ЕА82072113>			33705 - Хөгжлийн	1/25/2023	880,000.00	60,000.00	700,000.00	820,000.00	-12000
6	Бадамгэрэл Е378070961 <РД:Е378070961>			33705 - Хөгжлийн		2,350,000.00	-	2,350,000.00	2,350,000.00	төлөлт хийгээгүй
7	Бадамгэрэл С ЕЮ75032708 <РД:ЕЮ75032708>			33705 - Хөгжлийн	5/29/2023	940,000.00	60,000.00	880,000.00	940,000.00	-6000
8	Бат-Эрдэнэ Е366032255 <РД:Е366032255>			33705 - Хөгжлийн	1/20/2023	1,233,000.00	59,500.00	937,000.00	1,055,000.00	-11800
9	Бат-Эрдэнэ Наранбямба ЕП88112132 <РД:ЕП88112132>			33705 - Хөгжлийн		677,950.00	-	677,950.00	677,950.00	төлөлт хийгээгүй
10	Батбилэг Дондол ЕС67102018 <РД:ЕС67102018>			33705 - Хөгжлийн	3/28/2023	700,000.00	640,000.00	60,000.00	60,000.00	төлөлт хийгээгүй
11	БатбилэгД			33705 - Хөгжлийн		(120,000.00)	-	(120,000.00)	(120,000.00)	илүү төлөлт
12	Батболд Ж <РД:ЧБ86052211>			33705 - Хөгжлийн	1/24/2023	4,118,000.00	142,000.00	3,408,000.00	3,692,000.00	-28400
13	Батзориг М ЕД89061412 <РД:ЕД89061412>			33705 - Хөгжлийн		3,277,000.00	-	3,277,000.00	3,277,000.00	төлөлт хийгээгүй
14	Батсүрэн Мөнгөнсүх Е396051112 <РД:Е396051112>			33705 - Хөгжлийн		(60,000.00)	-	(60,000.00)	(60,000.00)	илүү төлөлт
15	Батсүрэн Цогтсайхан ЕВ74020912 <РД:ЕВ74020912>			33705 - Хөгжлийн	1/24/2023	1,160,000.00	60,000.00	860,000.00	980,000.00	-12000
16	Батсайхан Нямбаа ЕЮ84082612 <РД:ЕЮ84082612>			33705 - Хөгжлийн	3/16/2023	1,055,000.00	177,000.00	878,000.00	878,000.00	төлөлт хийгээгүй
17	Батхуяг Д ЕБ75061512 <РД:ЕБ75061512>			33705 - Хөгжлийн		2,690,000.00	-	2,690,000.00	2,690,000.00	төлөлт хийгээгүй
18	Баярмаа Банзрагч ЕП67101901 <РД:ЕП67101901>			33705 - Хөгжлийн	1/17/2023	700,000.00	60,000.00	400,000.00	520,000.00	-12000

зээлээ төлөх талаар мэдэгдэж ажилласан.

- ХХҮЕГ-ын хяналт шалгалт, дотоод аудит, мониторингийн газраас хийгдсэн хяналт шалгалтад хамрагдлаа. ХХҮЕГ-н Хяналт мониторингийн газарт 7 хөтөлбөр үйл ажиллагааны 2015-2022 оны санхүүжилт, эргэн төлөлт, хугацаа хэтрэлтийн судалгааг гарган цахимаар хүргүүлсэн.
- 06 дугаар сарын 05-07-ны өдрүүдэд “Хөдөлмөр эрхлэлтийн салбарын сургагч багш бэлтгэх сургалт”-д Газрын дарга, Хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн дарга, Хөдөлмөр эрхлэлтийн 2 мэргэжилтэн хамрагдаж, БАТЛАМЖ авсан.
- 2023 оны хагас жилийн тайлангуудыг тайлагналаа.
- Нийгмийн халамжийн санд орон нутгийн төсвөөс 30,000,000 төгрөгийн санхүүжилт авсан. Мөн нийгмийн халамжийн Улсын байцаагч Халамжийн санд хяналт шалгалт орж байгаатай холбоотойгоор 2021, 2022 оны Халамжийн сангийн бүрдүүлэлт зарцуулалт, хамрагдсан иргэд, тусгай хэрэгсэл нийлүүлсэн ААНБ, амралт сувилалын газрын судалгааг гарган өгч ажилласан.

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ЧИГЛЭЛЭЭР:

И халамж нэгдсэн системээр халамжийн үйлчилгээнд хамрагдах хүсэлтээ гаргасан 941 иргэний хүсэлтийг хүлээн авч хугацаанд нь шийдвэрлэсэн.

2023 оны 06 дугаар сарын тэтгэвэр, тэтгэмжийн олголтыг иргэдийн дансанд илгээлээ. Үүнд:

- ❖ Цалинтай ээжийн тэтгэмж 2622 иргэнд 127,6 сая төгрөг
- ❖ Жирэмсэн эхийн тэтгэмж 499 иргэнд 18,0 сая төгрөг
- ❖ Ихэр хүүхдийн тэтгэмж 1 иргэнд 2,0 сая төгрөг
- ❖ Алдарт эхийн одонгийн тэтгэмж 245 иргэнд 24,8 сая төгрөг
- ❖ Насны хишиг 3103 иргэнд 247,6 сая төгрөг
- ❖ Халамжийн тэтгэвэр 1301 иргэнд 361,4 сая төгрөг
- ❖ Асаргааны тэтгэмж 1046 иргэнд 83,8 сая төгрөг
- ❖ Амьжиргаа дэмжих мөнгөн тэтгэмж 982 иргэнд 112,7 сая төгрөг
- ❖ Ахмад настны хөнгөлөлт тусламж 179 ахмадад 41,7 сая төгрөг
- ❖ Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх хөнгөлөлт тусламж 82 иргэнд 6,0 сая төгрөг
- ❖ Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээг 146 өрхийн 277 том хүн, 379 хүүхдэд 7,5 сая төгрөг
- ❖ Хүүхдийн мөнгөн тэтгэмж 24287 хүүхдэд 2,428.7 сая төгрөг нийт 35003 иргэнд 3,461.8 сая төгрөг олгосон.

АХМАД, НАСТАН, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНД ЧИГЛЭСЭН:

- Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2023 оны 05 дугаар сарын 03-ны 4/579 тоот чиглэлийн дагуу ажил хөдөлмөр эрхлэж байгаа байнгын асаргаа шаардлагатай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хувийн хэрэгт хяналт шалгалтыг хийж гүйцэтгэлээ. 2022 оны 12 дугаар сарын байдлаар уг тэтгэмжийг авч байгаа 16 иргэн ажил хөдөлмөр эрхлэж байсан бол энэ оны 05 дугаар сарын байдлаар 6 иргэн хөдөлмөр эрхлэж, байгууллагаас шимтгэл төлөгдөж байсныг тодруулан дахин магадлуулахаар Аймгийн эрүүл мэндийн газарт Газрын даргын 06 сарын 19-ний өдрийн 278 тоот албан бичгийг хүргүүлээ.
- Засгийн газрын 2017 оны “Журам батлах, тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 197 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт Ахмад настанд үйлчилгээ үзүүлэх, дэмжлэг, хөнгөлөлт олгох журам”, 2 дугаар хавсралт “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд тусламж, хөнгөлөлт олгох журам”, 3 дугаар хавсралт “Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчих журам” шинэчлэн батлах тогтоолын төсөлтэй танилцаж 8 саналыг хариуцсан мэрэгжилтэнд цахимаар хүргүүлэв.
- Аймгийн ахмадын хороотой хамтран ажиллах гэрээг 2023,05,22-нд байгууж Сайншанд сумаас өдрийн үйлчилгээнд хамрагдах 1-р ээлжний 60 ахмад настан бүрэн хамрагдсан. Өдрийн үйлчилгээний явцын хяналтыг өдрийн эмчилгээчлөөт цаг, үдийн хөнгөн цай зэрэгт хийж, хэрэгжилтийн тайланг хүлээн авч хамрагдсан 60 иргэний мэдээллийн санг халамжийн нэгдсэн системд илгээн санхүүжилтийг олгоход бэлэн болсон. 2-р ээлжинд хамрагдах Даланжаргалан-20, Айраг-20 ахмад настны үйлчилгээг эхлүүлээ.
- Нийгмийн халамжийн сангаас Ахмад настны тухай хуулийн 12.5-д заасан “Ажиллаж байсан аж ахуйн нэгж, байгууллага нь дампуурсан буюу татан буугдсан болон бусад шалтгаанаар харьяалах аж ахуйн нэгж, байгууллага байхгүй болсон” ахмад настанд жилд хоёр удаа хүндэтгэл үзүүлдэг. Дээрх ахмад настны судалгаа мэдээллийг шинэчлэхээр Газрын даргын 2023 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 296 тоот албан бичгийг аж ахуйн нэгж байгууллагуудад хүргүүлээ.

- Аймгийн ЭМГ-аас зохион байгуулж буй Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд бэлгийн боловсрол олгох сургагч багш бэлтгэх сургалтанд “Хөгжлийн бэрхшээл ба хүний эрх” сэдвээр мэдээлэл өгсөн.
- ХБХЭМБНХСК-ын батлагдсан хуваарийн дагуу 06 сарын 06, 26-ны өдрүүдийн суурин хурал, 20 өдрийн Замын-Үүд сумын нүүдлийн хурлаар орж хугацаа сунгуулах хүүхдүүд болон шинээр орох хүүхдүүдийн ар гэрт мэдээлэл хүргэсэн. Батлагдсан хуваарийн дагуу 3 удаагийн хурлыг зохион байгуулж нийт 53 хүүхдийн асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн. Дээрх 53 хүүхдээс 9 хүүхэд шинээр байнгын асаргаа тогтоож 42 хүүхдийн байнгын асаргааг сунгаж 1 хүүхдийн хөгжлийн бэрхшээлтэй болохыг сунгаснаар аймгийн хэмжээнд нийт 290 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байна.

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ДЭМЖЛЭГ, ТУСЛАЛЦАА ЗАЙЛШГҮЙ ШААРДЛАГАТАЙ ӨРХ, ИРГЭНД ЧИГЛЭСЭН:

- Бүлгийн төсөл шалгаруулах ажлын хэсгийн хурлаар 9 бүлгийн төсөл хэлэлцэж 7 төсөл дэмжигдэхээр, 1 төсөл шалгуур хангаагүй тул хасагдахаар, 1 бүлгийн төслийн гишүүдтэй холбогдож тодруулга хийх гэсэн боловч утас нь холбогдоогүй тул хурлыг нээлттэй орхиж иргэнтэй холбогдсон тохиолдолд дахин хуралдуулах шийдвэр гаргасан байна.
- "Өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгаа"-нд хамрагдаж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн А/13 дугаар тушаалаар баталсан Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний босго онооноос доогуурт багтсан 3 өрхийг шинээр хамруулахаар албан бичгийг Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газарт хүргүүлэв. Ингэснээр манай аймагт дээрх үйлчилгээнд хамрагдаж байгаа 149 өрхтэй болно.
- Үндэсний статистикийн хорооны дарга, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн А/16, А/04 тоот тушаалаар Өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгааны маягт аргачлал шинэчлэгдэн батлагдсан. Үүний дагуу Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн “Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгаа зохион байгуулах тухай” А/36 тоот тушаалаар судалгааны удирдамж батлагдсан.
- Тус судалгаа нь улсын хэмжээнд 4 дэх удаагаа зохион байгуулагдаж байгаа бөгөөд энэ удаагийн судалгааны онцлог нь хосолмол аргачлалыг ашиглан нэлэнхүй бус өргөдлийн аргад суурилан, ядуу зорилтот өрхийг хамруулахаар зорьсон. Үүний дагуу улсын хэмжээнд 26,9 мянган өрх сонгогдсон бол манай аймгийн хувьд 478 өрхөөс судалгаа авах жагсаалт гарсан.
- Судалгааг зохион байгуулах ажлын хэсгийг Аймгийн Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн А/362 тоот захирамжаар 11 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан бөгөөд эдгээр өрхүүдийг судалгаанд бүрэн хамруулсан.
- Сайншанд сумын Амьжиргаа дэмжих зөвлөлийн хурлыг зохион байгуулж 20 иргэний өргөдлийг хэлэлцэж 16 иргэний өргөдлийг бүрэн шийдвэрлэж 4 иргэний хүсэлтийг дахин нягтлахаар хойшлуулсан.

ДӨРӨВ. САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТЭС

Зорилтод арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн явц:

Улсын төсвийн байгууллагуудын тогтмол зардлын санхүүжилтэд 96 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон.
Орон нутгийн төсвийн байгууллагад 1.7 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон.
Орлогын төлөвлөгөө 6 дугаар сарын байдлаар 32.4 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээс гүйцэтгэлээр 26.0 тэрбум төгрөгийн орлого төвлөрч 6.4 тэрбум төгрөгөөр орлого тасарч 80.2 хувийн биелэлттэй гарсан.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 20 аж ахуй нэгжид 3.4 тэрбумын санхүүжилтийг олгосон. Хэлтсийн төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтнүүд 2023 оны 06 сарын 01-ний өдрөөс 06 сарын 29-ны хооронд нийт 2359 гүйлгээний 24.4 тэрбум төгрөгийн төлбөр тооцоог төлбөрийн хүсэлт, хяналтын хуудас анхан шатны баримтын бүрдлийг хянаж Засгийн газрын санхүүгийн удирдлага мэдээллийн системээр дамжуулан ажилласан.

Ахмадын сангийн 17 байгууллагын хүсэлтийг үндэслэн 12.8 сая төгрөгийн нэмэлт төсвийн зарцуулах эрхийг нээж ажилласан.

Нэмэлт санхүүжилтийн 95 байгууллагын хүсэлтийг үндэслэн 568.9 сая төгрөгийн нэмэлт төсвийн зарцуулах эрхийг нээж ажилласан.

Шинээр байгуулагдсан 8 аж ахуйн нэгж байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээг үндэслэн e-balance системд бүртгэн анхаарах асуудлуудын талаар заавар, зөвлөгөө өгч ажилласан.

Ахмадын сангийн данс шинээр нээлгэх Хөвсгөл сумын Соёлын төвөөс ирүүлсэн хүсэлтийг үндэслэн Сангийн яамны Төрийн сангийн газарт албан бичиг хүргүүлэн төрийн санд бүртгэлийн дансыг нээлгэж ажилласан.

Аймгийн 2023 оны 6 дугаар сарын төсвийн хуваарьт өөрчлөлт оруулж, төсвийн баазыг Сангийн яаманд хүргүүлэн татуулсан.

Шилэн дансны хуулийн дагуу тухай бүр байршуулах төсөв хөрөнгөтэй холбоотой 41 захирамжийг байршуулсан.

Сумын орон нутгийн хөгжлийн сангийн 2023 онд батлагдсан төсвийн дагуу 11 сумын 1.2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон. Санхүүжилтийг олгохдоо анхан шатны баримт, гүйцэтгэлийн тайлан, захирамж, шийдвэрийг үндэслэн аймгийн Засаг даргын зөвшөөрлөөр олгосон.

Мэргэжлийн тасралтгүй хөгжил 2023 зүүн бүсийн салбаруудын мэргэшсэн нягтлан бодогчдын сургалт, зөвлөгөөнийг 06 сарын 16,17-ны өдрүүдэд зохион байгуулсан.

Мэргэшсэн нягтлан бодогчдын эрх олгох бүсчилсэн шалгалтыг 06 сарын 09,10-ны өдрүүдэд зохион байгууллаа. Тус шалгалтад Говьсүмбэр, Дорноговь аймгийн 40 хүн шалгалтад хамрагдан шинээр 1 мэргэшсэн нягтлан бодогчтой болсон.

Үр дүнд суурилсан төсвийн төлөвлөлт хийх арга зүйн сургалтыг 2023 оны 6 сарын 27,28-ны өдрүүдэд зохион байгуулсан.

Төрийн сангийн цахим удирдлагын системд онлайнаар төлбөр тооцоог хийж байгаатай холбогдуулан сумд болон аймгийн төвийн байгууллагуудын нягтлан бодогчдод мэргэжил арга зүйгээр ханган ажиллаж байна.

Санхүүгийн хяналт, аудитын алба:

“Зорилтот арга хэмжээний хэрэгжилтийн явц”

Аймгийн Засаг даргын баталсан 2023 оны санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитын нэгдсэн удирдамж, төлөвлөгөөний биелэлтийг ханган ажиллаж байна.

“Цаг үеийн ажлын мэдээлэл”

Албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн баталсан 01 тоот удирдамжийн хүрээнд Боловсрол шинжлэх ухааны газрын 2021-2022 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж гүйцэтгэсэн.

Албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн баталсан 14 тоот удирамжийн хүрээнд Сайншанд сумын 8 дугаар цэцэрлэг, 15 тоот удирдамжийн хүрээнд Сайншанд сумын 4 дүгээр цэцэрлэгүүдийн 2021-2022 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд хяналт шалгалт үргэлжилж байна.

Актын төлбөрийн үлдэгдлээс 15389,4 мянган төгрөгийг барагдуулж орон нутгийн орлогын дансанд төвлөрүүлсэн.

Татварын хэлтэс:

Зорилтот арга хэмжээний хэрэгжилтийн явц.

Улс ба орон нутгийн төсөвт **3380,9** сая төгрөгийн татварын орлого төвлөрүүлсэн.

Тайлант хугацаанд цахим татварын мэдээллийн шинэ системийг хэрэгжүүлэн 5 төрлийн нийт 288 татварын тайлан, 278 хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэн ажилласан. 6 дугаар сард 70521288 нэгдсэн дуудлагын дугаараар 320, өрөөгөөр -471 татвар төлөгчдөд Татварын хууль, НӨАТ-ын урамшууллын систем, Цахим татварын мэдээллийн шинэ системийн заавар зөвлөгөөг өгсөн.

Дуудлагаар татварын үйлчилгээ үзүүлэх үйлчилгээ орон нутагт хэрэгжиж 1800-1288-д 1568 дуудлага ирж зөвлөгөө мэдээллийг өгч, ирүүлсэн 61 гомдлыг хуваарилан 93 -г шийдвэрлэж баталгаажуулсан.

Аймгийн Улсын бүртгэлээс шинээр үүссэн 13 хуулийн этгээдийн мэдээллийг ТУНС-д бүртгэж, НӨАТ суутган төлөгчөөр 46 хуулийн этгээдийг бүртгэсэн байна.

Газар шилжилт хийж байгаатай холбогдуулан газрын төлбөрөө төлж барагдуулсанд хяналт тавих- 10 татвар төлөгч газар эзэмших эрх шилжүүлж 1,743,610 төгрөгийн төлбөрөө бүрэн төлж барагдуулсан.

Статистикийн хэлтэс:

Зорилтод арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн явц:

Дорноговь аймгийн нийгэм, эдийн засгийн 2023 оны 5 дугаар сарын танилцуулгыг боловсруулж, хэлтсийн цахим хуудас болон фэйсбүүк хуудсанд байршуулан, 600 гаруй хэрэглэгчдэд цахимаар, тархаасан.

Гол нэр төрлийн 12 бараа бүтээгдэхүүний үнэ болон нэмэлтээр 54 нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний үнийг долоо хоног бүрийн Даваа гаригт Сайншанд сумын хүнсний зах, дэлгүүрээс судалж, програмд шивэн, хугацаанд нь Үндэсний статистикийн хороонд дамжуулав.

Сар бүрийн 21-нд хэрэглээний үнийн 313 нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний үнийг аймгийн төвийн хүнсний зах, дэлгүүрээс судалж программд шивэн, хугацаанд нь Үндэсний статистикийн хороонд дамжуулсан. Мөн Айраг, Даланжаргалан, Эрдэнэ, Замын-Үүд, Хатанбулаг сумдын мэргэжилтнүүд 145 нэр төрлийн бараа бүтээгдэхүүний үнийг программд шивж Үндэсний статистикийн хороонд дамжуулав.

Аж үйлдвэрийн сарын мэдээ /АҮ-1/, зочид буудал, зоогийн газрын үйл ажиллагааны сарын мэдээ /А-ЗГ-1, А-ЗБ-1/, зочид буудал, зоогийн газрын хүчин чадлын эхний хагас жилийн мэдээ /А-ЗГ-2, А-ЗБ-2/, худалдааны салбарын сарын /ХУ-1/ мэдээ, худалдааны салбарын /ХСҮ/, үйлчилгээний салбарын үйлдвэрлэгчийн үнэ /зочид буудал, зоогийн газар, тээвэр, холбоо/ /ҮСҮ-1/, хөдөө аж ахуйн /ХАА-1, ХАА-2, ХАА-3, ХАА-6/ мэдээг сум, аж ахуйн нэгж, иргэдээс цуглуулан авч нэгтгэн нягтлан шалгаж, программд шивж дамжуулсан.

Малын 2023 оны хагас жилийн түүвэр судалгаа 5-р сарын 30-ны өдрөөс 6-р сарын 06 н ыг дуустал судалгааны мэдээлэл цуглуулах ажил явагдсан. Уг түүвэр судалгаанд 14 суманд 14 тоологч ажиллаж 8 аж ахуйн нэгж, 955 өрхийг түүвэр судалгаанд бүрэн хамруулан ажилласан.

Өрхийн нийгэм, эдийн засаг, Ажиллах хүчний судалгаанд 6-р сард судлаач Б.Мөнх-Эрдэнэ, А.Дамчой, нар ажиллаж байна. Сайншанд, Хөвсгөл, Өргөн, Хатанбулаг сумдын өрхөөс мэдээллийг цуглуулж байна. Ажиллах хүчний судалгааны хяналтаар мэргэжилтэн Н. Түвшинбаатар Улаанбадрах сумын 3-р багт ажилласан.

ТАВ. ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТЭС:

- Тендерийн худалдан авалтын үйл явцын талаар ГХБХБГ, ОНӨГ-ын холбогдох албан тушаалтнуудтай хуралдсан. 2023 онд батлагдсан нийт 99 төсөл арга хэмжээний нийт гүйцэтгэл 98,9 хувийн гүйцэтгэлтэй байна.

- Тендерт шалгарсан гэрээ байгуулах эрх бүхий 21 компанитай ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан. Мөн зураг төсөл боловсруулах 15 төсөл арга хэмжээний гэрээ байгуулсан.
- Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй 47 төсөл арга хэмжээнд 15,5 тэрбум төгрөгийн санхүүжилтийн эрхийг нээсэн.
- Газрын доорх усны эх үүсвэрийн хүрэлцэхүйц ашиглалтын нөөц тогтоох ус ашиглалтын зөв зохистой, үр ашигтай хэрэглээг бий болгох зорилгоор Сайншанд сумын 2 дугаар багт байрлах Хүүхдийн зуслангийн газар доорх усны гидрогеофизикийн хайгуул хийсэн “Гидроинженергеологи” ХХК-ийн гүйцэтгэлийн ажилд 1.500.000 төгрөгийн зардал шийдвэрлэх захирамж гаргасан.
- Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 03-ны өдөр баталсан 10/06 дугаартай “Дорноговь аймгийн 2023 оны төсөв батлах тухай” тогтоолд Мал эмнэлгийн газарт тусгагдсан вакцины зардалд 143.421.4 сая, үйлчилгээний зардалд 277.078.0 сая тус тус зардалд захирамж гаргасан.
- Мал амьтны гоц халдварт бог малын мялзан өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх зорилгоор Айраг, Даланжаргалан суманд аймгийн Мал эмнэлгийн газар, Онцгой байдлын газар, Цагдаагийн газар, Тагнуулын хэлтсийн тус тус албан хаагчид хамтарсан ажил гүйцэтгэхэд шаардагдах удирдамжийг аймгийн Засаг даргын орлогч Г.Март даргаар батлуулж хүргүүлсэн.
- Дорноговь аймгийн Засаг даргын Тамгын газар, Аж үйлдвэрийн паркийн технологийн дамжуулах төвтэй хамтран ажиллахаар байгуулсан 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01/2023 дугаар гэрээний үр дүнг үндэслэн Айраг, Даланжаргалан сумдад 37 сая төгрөгийн зардал гаргах аймгийн Засаг даргын захирамж гаргасан.
- Эдийн засаг хөгжлийн сайд, БОАЖСайдын гэрээний 2023 оны хагас жилийн тайланг бэлэн болгосон.
- ЗГ-ын иргэд олон нийттэй харилцах 11-11 төвд ирсэн 40 өргөдөл гомдлыг шийдвэрлэсэн.
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 3 төсөл арга хэмжээний санхүүжилт хүссэн гүйцэтгэлийг PIMIS программд шивж Сангийн яам руу илгээсэн.
- Өвс тэжээлийн тооцоо хийж сумдын Засаг дарга нарт төлбөр барагдуулах чиглэл өгсөн.
- Хэлтсийн албан хаагчид бүгд хувийн хэргээ бүрдүүлж өгсөн.
- Төрийн аудитын газраас Байгаль орчин ачлал жуулчлалын чиглэлээр хийгдэж буй гүйцэтгэлийн аудитад шаардагдах сүүлийн 5 жилийн баримт материал гаргаж өгсөн.
- Аймгийн ИТХ-аар баталсан Дорноговь аймгийн аж үйлдвэр хөгжлийн стратеги төлөвлөгөөг сурталчлан таниулах, зорилтот 8 сумдад хоршооллын системийг дэмжих хөтөлбөр болон системийн загвар 5 төслийг хүлээлгэн өгөх ажлыг “Аж үйлдвэрийн паркийн технологи дамжуулах төв”-тэй хамтран зохион байгуулсан.
- Төрийн албан хаагчийн хувийн хэрэг бүртгэлийн жагсаалтыг бүрэн гүйцэт болгон хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлсэн.
- Мал эмнэлгийн салбарын ажилтны баяр 2023 оны 06-р сарын 10-д тохиож байгаатай холбогдуулан “Хөгжлийн төлөө хамтдаа-2” аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан Замын-Үүд сумын малын эмч С.Сугаржав, Сайхандулаан сумын малын эмч М.Дөш нарыг аймгийн Засаг даргын “Өргөмжлөл”-өөр шагнасан.
- Аймгийн нөөцийн агуулахад хадгалагдаж байсан болон шинээр татан авчирсан өвс тэжээлээс сумдуудын авсан өр төлбөрийн тооцоог гаргахад 90,517,000 төгрөг болсон.
- Аймгийн хэмжээнд үндэсний аюулгүй байдлыг хангах арга хэмжээний 2023 оны нэгдсэн төлөвлөгөөний хагас жилийн хэрэгжилтийг Хууль, эрх зүйн хэлтэст хүргүүлсэн.
- Эрчим хүчний сайдын гэрээний хагас жилийн тайланг хүргүүлсэн.

- Газартай холбоотой эрх шилжүүлэх, өмчлөх зэрэг 6 захирамжийг гаргаж ГХБХБГ-т хүргүүлсэн.
- Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамнаас зарласан 202302156 дугаартай тендерийн багц №13 “Шинэ хөдөө” Дорноговь-хүлэмж нийлүүлэх 230505/05/05-289 тоот гэрээ байгуулсан “Мөнх ногоон тал” ХХК-ийн хүлэмжийг хүлээн авах ажлын хэсэг, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох төсөл сонгон шалгаруулах дэд хороог аймгийн Засаг даргын захирамжаар байгуулсан.
- Аймгийн хэмжээнд 2023 оны 07 дугаар сарын 22, 23-ны өдрүүдэд Иххэт суманд зохион байгуулах хурдан морины “Хойд бүс”-ийн уралдааны товыг аймгийн Засаг даргын захирамж батлуулсан.
- Аймгийн ИТХ-аар баталсан Дорноговь аймгийн аж үйлдвэр хөгжлийн стратеги төлөвлөгөөг сурталчлан таниулах, зорилтот сумдад хоршооллын системийг дэмжих хөтөлбөр болон системийн загвар 5 төслийг хүлээлгэх, гардуулж өгөх ажлаар зарим сумдад томилолтоор ажилласан.
- Хэлтэст тухайн сард нийт 125 албан бичиг ирж, хариутай 55, бичгийг хугацаанд нь шийдвэрлэж, бусад 70 албан бичиг нь мэдээлэлд авах болон цаашид авч хэрэгжүүлэх тухай байсан.
- Хамарын хийд”, “Ханбаян зүрх” уул орчимд худалдаа, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч нэр бүхий 10 иргэнээс ирүүлсэн өргөдлийг судлан шийдвэрлэх чиглэлийг Сайншанд сумын Засаг даргад чиглэл болгосон.
- Аймгийн Засаг даргын захирамжаар худалдаа, үйлчилгээ, аялал жуулчлалын салбарт холбогдох стандартыг мөрдүүлэх, хяналт шалгалт зохион байгуулах ажлын хэсэг, удирдамжийг баталсан.
- Баяр наадмын өдрүүдэд гадаад, дотоодын жуулчид хүлээн авах “Жуулчдын отог” байгуулахад сум, аймгаас гарах зардлын тооцоо, талбайн зохион байгуулалтын зураглалыг гарган удирдлагад танилцуулсан.
- Засгийн газрын 2023 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг гарган холбогдох газарт хүргүүлсэн.

ЗУРГАА: ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх чиглэлээр:

Агентлаг, сумдын 2022 оны үйл ажиллагааны болон аймгийн бодлогын баримт бичгүүдийг бүрэн архивлаж дуусгасан. Үүнд:

1. Агентлагийн төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн тайлан – 1 баримт
2. Сумдын 2022 оны үйл ажиллагааны гүйцэтгэлд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнд үндэслэсэн зөвлөмж – 1 баримт
3. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн сургалт, зөвлөгөөний сургалтын материал – 1 баримт
4. Сумдын эдийн засаг, нийгмийн үзүүлэлтийн тайлан – 1 баримт
5. Агентлагуудын эдийн засаг, нийгмийн үзүүлэлтийн тайлан – 1 баримт

Сумдын төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн тайлан – 1 баримт зэрэг болно.

Шинээр гарсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хяналтад авч, бүртгэл хөтөлж, удирдлагуудад танилцуулах:

Монгол Улсын Засгийн Газрын 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 221 дүгээр “Зарим аймаг байгуулагдсаны ойг тэмдэглэх болон баяр наадмын хугацааг тогтоох” тухай тогтоол, 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 212 дугаар “Ой тэмдэглэх тухай” тогтоол, 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 213 дугаар тогтоол “Цалингийн хэмжээ тогтоох итгэлцүүр, түүнийг хэрэглэх төрийн байгууллагын жагсаалт, орон тооны дээд хязгаар тогтоох тухай” тогтоол, 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн хуралдааны 23 дугаар “Шил ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” тэмдэглэл, 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 203 дугаар “Алсын хараа-2025 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилт, онцлох ажлуудын хэрэгжилтийн явцын талаар зөвлөлдөх уулзалт зохион байгуулах тухай” тогтоол, 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 203 дугаар “Улсын тэмдэгтийн хураамжийн хэмжээг тогтоох тухай” тогтоол, 2023 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн хуралдааны 21 дүгээр “Яам болон аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан Засгийн газрын гишүүдэд танилцуулав” тэмдэглэл, 2023 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн хуралдааны 21 дүгээр “XVIII.3.Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу газрын тосны ашиглалтын үйл ажиллагаа явуулж байгаа “Петрочайна Дачин Тамсаг” ХХК болон “Доншен газрын тос (Монгол)” ХХК-ийн газрын тосны ашиглалтын үйл ажиллагаа болон цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав тэмдэглэл зэргийг хяналтад авч, удирдлагуудад танилцуулан, бүртгэлжүүлсэн.

Монгол Улсын сайд нартай аймгийн Засаг дарга байгуулсан гэрээний хэрэгжилт :

Монгол Улсын Шадар сайд бөгөөд эдийн засаг, хөгжлийн сайд болон аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн хэрэгжилтийн 2023 оны эхний хагас жилийн тайлангийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, эхний хагас жилийн биелэлтийг 92.5%-тай үнэлсэн.

Цахим хөгжил, харилцаа холбооны сайд болон аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн хэрэгжилтийн 2023 оны эхний хагас жилийн тайлангийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, эхний хагас жилийн биелэлтийг 81.9%-тай үнэлсэн.

Гадаад харилцааны сайд болон аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн хэрэгжилтийн 2023 оны эхний хагас жилийн тайлангийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, эхний хагас жилийн биелэлтийг 98.1%-тай үнэлсэн.

Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны дарга болон аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн хэрэгжилтийн 2023 оны эхний хагас жилийн тайлангийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, эхний хагас жилийн биелэлтийг 91.2%-тай үнэлсэн.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд болон аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн хэрэгжилтийн 2023 оны эхний хагас жилийн тайлангийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, эхний хагас жилийн биелэлтийг 77.4%-тай үнэлсэн.

Хууль зүй, дотоод хэргийн сайд болон аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн хэрэгжилтийн 2023 оны эхний хагас жилийн тайлангийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, эхний хагас жилийн биелэлтийг 91.3%-тай үнэлсэн.

Эрчим хүчний сайд болон аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн хэрэгжилтийн 2023 оны эхний хагас жилийн тайлангийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, эхний хагас жилийн биелэлтийг 84.7%-тай үнэлсэн.

Эрүүл мэндийн сайд болон аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн хэрэгжилтийн 2023 оны эхний хагас жилийн тайлангийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, эхний хагас жилийн биелэлтийг 95%-тай үнэлсэн.

Боловсрол, шинжлэх ухааны сайд болон аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн хэрэгжилтийн 2023 оны эхний хагас жилийн тайлангийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, эхний хагас жилийн биелэлтийг 90.2%-тай үнэлсэн.

Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд болон аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн хэрэгжилтийн 2023 оны эхний хагас жилийн тайлангийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, эхний хагас жилийн биелэлтийг 80.6%-тай үнэлсэн.

Барилга, хот байгуулалтын сайд болон аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн хэрэгжилтийн 2023 оны эхний хагас жилийн тайлангийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, эхний хагас жилийн биелэлтийг 86.1%-тай үнэлсэн.

Соёлын сайд болон аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн хэрэгжилтийн 2023 оны эхний хагас жилийн тайлангийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, эхний хагас жилийн биелэлтийг 80.6%-тай үнэлсэн.

Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргатай аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн хэрэгжилтийн 2023 оны эхний хагас жилийн тайлангийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, эхний хагас жилийн биелэлтийг 90.2%-тай үнэлсэн.

Бодлогын баримт бичгүүдэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх:

Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний 305 заалт, Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 277 заалтын хэрэгжилтийг тус бүрт нь үнэлж, дундаж үнэлгээ, үр дүнтэй ажлууд болон эрчимжүүлэх шаардлагатай ажлуудыг ангилан хэлтсийн ахлах мэргэжилтнээр хянуулсан.

Монгол Улсын жилийн хөгжлийн төлөвлөгөөний 22 заалтаас 11 заалтын хэрэгжилтийг хянан цахим санд байршуулсан.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр арга зүйн зөвлөгөө өгөх:

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнөөс хасуулах заалтын санал авч нийт 10 гаруй агентлаг, сумдын 80 орчим заалтыг хяналтаас хассан.

2023 оны эхний хагас жилийн тайлантай холбоотойгоор “Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөө”, “Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр”-өөс 8 агентлаг, 5 сумын 60 орчим заалтыг чиг үүрэгт нь хамаарахгүй гэсэн үндэслэлээр тайлагналтаас нь хассан.